



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД,
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭВТЭР АШИГЛАХ ГАРЫН АВЛАГА



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.
Утас: 319658, 70140459
Вэб хаяг: www.munkhiin-useg.mn

ISBN 9919-9519-2-7



9 789919 951924



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ




ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД,
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭВТЭР АШИГЛАХ ГАРЫН АВЛАГА



2019 он

ННА 74.3
ДАА 371.9
Э-94

Энэхүү ном нь Монгол Улсын “Зохиогчийн эрхийн тухай” хуулиар баталгаажсан тул эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, цахим болон бусад хэлбэрээр хувиран олшруулах, түгээн тараахыг хориглоно.

Цаасны хэмжээ: В5
Хэвлэлийн хуудас: 5.0 х.х

“Мөнхийн Үсэг” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ISBN: 978-9919-9519-2-4

ГАРЧИГ

Товчилсон үгийн тайлбар.....	4
Удиртгал.....	5
НЭГ. “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн танилцуулга.....	7
ХОЁР. Эхийн эрүүл мэндийн тухай мэдээлэл.....	10
ГУРАВ. Төрөлтийн талаарх тэмдэглэл.....	16
ДӨРӨВ. Төрсний дараах 1-6 долоо хоногтойд.....	18
ТАВ. Хүүхдэд бодит үзлэг хийх.....	20
ЗУРГАА. Хүүхдэд хэмжилт хийх.....	24
ДОЛОО. Нэг хүртэлх насны хүүхдийн хяналт	33
НАЙМ. Дархлаажуулалтыг шалгах	38
ЕС. Хүүхдийн хөгжлийн үе шатны үзүүлэлтүүд.....	40

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
БЖИ	Биеийн жингийн индекс
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ОНБТ	Олон найрлагат бичил тэжээл
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СЭМТ	Сумын эрүүл мэндийн төв
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХЭМД	Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага

УДИРТГАЛ

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA) нь 2015 оны 8 дугаар сараас 2019 оны 7 дугаар сар хүртэлх хугацаанд “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн эрхэм зорилго нь хүүхэд бүр хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг ба боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлж, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх, чанартай боловсрол олгох тогтолцооны загварыг боловсруулахад чиглэсэн.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд бага насны хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, хөгжлийг дэмжих, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлж холбогдох дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах зорилгоор сонгосон аймаг, дүүрэгт “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” ашиглалтыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулах явцад энэхүү гарын авлагыг боловсруулсан болно.

Хөгжлийн дэмжлэгийг эрт эхлэх нь хүүхдийн хөгжлийг боломжит дээд хэмжээнд хүргэхэд чухал ач холбогдолтой. Эрүүл мэндийн ажилтнууд, гэр бүл, асран хамгаалагчид хамтран Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг ашиглаж хүүхдийн өсөлт хөгжлийг хянах нь хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийг дэмжих суурь болдог. Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг ашиглан өсөлт, хөгжлөөр хоцорч байгаа хүүхдийг эрт анзаарч илрүүлснээр хүүхэд, түүний гэр бүлийг шаардлагатай дэмжлэгийн үйлчилгээнд холбох боломж бүрдэнэ.

Энэхүү гарын авлагыг хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүдэд зориулан боловсрууллаа.

Нэгдүгээр бүлэгт, Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн ерөнхий агуулгыг танилцуулав.

Хоёроос наймдугаар бүлэгт, Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн үзүүлэлт бүрээр хэрхэн ашиглах талаар дэлгэрэнгүй тайлбарласан.

Есдүгээр бүлэгт, 0-60 сартай хүүхдийн хөгжлийн үзүүлэлт, хөгжлийг шалгах арга, эцэг эхэд зөвлөгөө өгөх арга зүйг эмхэтгэн оруулж, аравдугаар бүлэгт, тусгайлан тэмдэглэх зүйлүүдийн талаар тайлбарлав.

Энэхүү гарын авлагыг өрх, сумын эрүүл мэндийн төв өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж, хүүхэд бүрийн эрүүл мэнд, хөгжлийг дэмжих нь “Бүх нийтийг эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш хамруулах” Тогтвортой Хөгжлийн Зорилтыг хангахад тодорхой хувь нэмэр болох юм.

1 “ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭВТЭР”-ИЙН ТАНИЛЦУУЛГА

Эх, хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн бүх байгууллагуудад Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр (цаашид ЭХЭМД гэх) хангалттай байх хэрэгтэй.

Жирэмсэн эмэгтэй анх удаа хяналтад орохоор ирэхэд ЭХЭМД-ийг олгоно.

ЭХЭМД-ийг олгохдоо эрүүл мэндийн ажилтан дараах зүйлүүдийг эхэд сайтар ойлгуулж тайлбарлаж өгөх үүрэгтэй;

- Жирэмсэн эх хяналтад орохоор анх ирэхэд болон нэг хүртэл настай, ЭХЭМД байхгүй хүүхдэд энэхүү дэвтрийг өгнө
- Эхний хуудсанд жирэмсэн эмэгтэй, түүний гэр бүлийн гишүүдэд зориулсан мэдээлэл болон дэвтрийн агуулгыг тэмдэглэсэн
- Жирэмсний хяналтад үзүүлэх, амаржих, хүүхдээ дархлаажуулах, өвчтэй хүүхдийг үзүүлэхээр эмнэлэгт очихдоо дэвтрээ заавал авч явна
- ЭХЭМД нь таны хүүхдийн өсөлт, хөгжил багадаа ямар байсныг хэлж өгөх түүх болон үлддэг тул дэвтрээ цэвэр нямбай хөтөлж хадгалахыг ээж болон гэр бүлийн гишүүдэд сайтар ойлгуулж өгнө
- ЭХЭМД-ийг хаяж үрэгдүүлсэн бол дэвтэр анх өгсөн эрүүл мэндийн байгууллага, ажилтанд мэдэгдэж, дахин дэвтэр өгөхийг хүсэх ба шаардлагатай мэдээллийг дахин нөхөж бөглөнө
- ЭХЭМД нь эх, хүүхдийн эрүүл мэндийг 2 үе шаттай хянана:
 - 1) Жирэмсний бүхий л хугацаа, амаржих үе ба төрсний дараах 6 долоо хоног дахь эх нярайн эрүүл мэнд
 - 2) Хүүхдийг төрсний дараах 6 долоо хоногтойгоос 6 нас хүртэл өсөлт хөгжил, эрүүл мэндийг хянана
- Дээрх 2 үе шат тус бүрт эх хүүхдийн эрүүл мэндийн талаарх заавар зөвлөгөө байна
- Хүүхэд бүр нэг ЭХЭМД-тэй байна. Хэрэв ихэр бол дэвтрийн жирэмсний хэсгийг хуулж бичин, ихэр тус бүрт дэвтрийг бөглөж өгнө

Сургалтад хамрагдсан өрх, сумын эмч сувилагч нар нь бусдадаа (багт ажиллаж буй) ЭХЭМД-ийг хэрхэн ашиглах талаар зааж өгөх нь чухал.

ЭХЭМД нь эрүүл мэндийн үзлэг, тусламж үйлчилгээ, хяналт, тандалт, зөвлөгөө өгөх зэргийг агуулсан эх хүүхдийн эрүүл мэндийг хянах арга хэрэгсэл юм.

Эхчүүдэд жирэмсэн үеэс нь энэ дэвтэрт бичигдсэн зөвлөгөөг уншуулж, ойлгуулах ба хүүхдээ төрүүлэх болон төрсний дараах 6 долоо хоногт эх хүүхдийг хамтад нь хянана.

Хүүхдийг эхийн хэвлийд бүрэлдэх үеэс төрөх, төрсний дараа нярайгаас 6 нас хүртэлх хугацаанд ЭХЭМД-ийг ашиглан эрүүл мэндийн байгууллага тогтмол хянана.

Дэвтрийн үндсэн агуулга нь:

- Эхийн нас, ажил, боловсрол, цусны бүлэг
- Хүүхдийн төрсний гэрчилгээ болон бусад баримт бичиг
- Эхийн жирэмсэн үеийн мэдээлэл, жирэмсний хяналтад орсон хугацаа, хоолны дэглэм
- Жирэмсэн үед зайлшгүй мэдэх зөвлөгөө
- Амаржих үеийн мэдээллүүд
- Амаржсаны дараах эхийн эрүүл мэндийн байдал, үйлчилгээ
- Хүүхдийг насаар үечилсэн хяналт
- Хүүхдийн асаргаа, хоол тэжээлийн байдлын талаар эцэг эхэд өгөх зөвлөгөө
- Хүүхдийн хөгжлийг үзүүлэлтүүдийг үнэлэх хуудсууд
- Үзлэгийн хуудсууд
- Жин өндрийн хүснэгт
- Зонхилон тохиолдох өвчний үеийн эмчилгээ, зөвлөгөө
- Дархлаажуулалтын товллол, Амин дэм А, Д, К

Эрүүл мэндийн ажилтан ЭХЭМД-ийг жирэмсэн эмэгтэйд олгохдоо агуулгын талаар сайтар тайлбарлаж, эхнэр нөхөр хамтдаа уншиж ашиглахын чухлыг ойлгуулна.

Хүүхдийн өсөлт хөгжлийг үзэж үнэлэх нь 2 хэсэгтэй. Үүнд:

- 1) Эцэг эх, асран хамгаалагчийн тэмдэглэх хуудас
- 2) Эрүүл мэндийн ажилтнуудын тэмдэглэх хуудас

Өрх, сумын эмч нь эцэг эхэд хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг өөрсдөө хэрхэн үнэлэх талаар сайтар ойлгуулж хэлж өгч ойлгосон эсэхийг шалгах ёстой.

Хүүхэд асран хамгаалагчид, эцэг эхэд дэвтрийн хөх булантай хуудсан дахь мөлхөж эхэлсэн, хөлд орж явсан, ярьж эхэлсэн гэх мэтийг тэмдэглэж хүүхдийн амьдралын чухал үйл явдлуудын үед нь жижиг зураг нааж тэмдэглэж байх нь хүүхдийг насанд хүрсэн үед нь дурсгалтай гэдгийг хэлж өгнө.

Хожим хүүхэд ээж аавынхаа тэдгээр тэмдэглэлийг уншихдаа багад нь хичнээн их хайр, халамж, анхаарал тавьдаг байсныг улам ойлгох болно.

Эх хүүхдээ дагуулж ЭМБ-д ирэх, эрүүл мэндийн ажилтан гэрээр эргэлт хийхдээ дэвтэр дэх тэмдэглэгээг шалгах ба хэрэв ээж нь сайн ойлгоогүй бол яаж тэмдэглэхийг зааж зөвлөнө.

Хэрэв ээж нь бичиг үсэг мэдэхгүй бол эрүүл мэндийн ажилтан яг байгаа мэдээллийг асууж тэмдэглэнэ.

Мэдээлэл үнэн зөв ойлгомжтой бичигдэх ёстой. Үүнд:

- Эх хүүхдийн нэр нь гэр бүлийн мэдээлэлд байгаатай ижил байна.
- Төрсөн он, сар, өдөр
- Хаяг: Аймаг, хот, дүүрэг, хороо, сум гэх мэт бүгдийг бичнэ
- Эхийн нэр: Хүүхдийн төрсний гэрчилгээн дээр байгаа эхийн нэр
- Төрсөн огноо: ... оны ... сарын ...
- Яс үндэс
- Эрхэлдэг ажил
- Боловсрол
- Ам бүл
- Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар

Хүүхдийн талаарх мэдээлэл (Төрсний гэрчилгээнд байгаатай ижил байна)

- Хүүхдийн овог нэр. Үүнд төрсний гэрчилгээ ба ЭХЭМД-ийн хавтас дээрх нэр нь ижил байна
- Хүйс, нас
- Төрсөн газар: Аймаг, хот, дүүрэг, хороо, сум
- Гэрийн хаяг
- Төрсөн он, сар, өдөр, цаг
- Регистрийн дугаар

2 ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Эхийн архаг өвчнүүд: Цусны даралт ихсэх, шээсний замын өвчнүүд, чихрийн шижин, сүрьеэ, бамбай булчирхайн өвчнүүд, гепатит зэрэг жирэмслэлтэд нөлөөлдөг архаг өвчнүүдийг асуух ба ийм өвчингүй бол дараах байдлаар тэмдэглэн дараагийн хэсэгт шилжинэ.

Үгүй ✓

Тийм

- Дархлаажуулалт хийлгэсэн байдлууд
- Мэс ажилбар хийлгэж байсан эсэх
- Хорт зуршлууд
- Нөхрийн эрүүл мэндийн байдал
- Өмнөх жирэмслэлтийн түүх
- Одоо байгаа хүүхдийн тоо
- Дутуу төрж байсан эсэх
- Зулбаж байсан эсэх, хэдэн удаа зэргийг тэмдэглэнэ.

Хэрэв эх нь архаг өвчний учир эмчилгээ хийлгэж байсан бол оношийг бичнэ. Жишээ нь: Эх цусны даралт ихэсч байсан бол цусны даралт ихсэх гэдгийн өмнө ✓ гэж тэмдэглэх ба эхийг аймаг дүүргийн ЭМТ, нэгдсэн эмнэлэгт хянуулж амаржихыг санал болгоно.

Анх удаа жирэмсний хяналтад ирэхэд нь дараах асуултуудыг асууж тэмдэглэнэ.

- Эхийн жирэмсэн болсон насыг асууж өндрийг хэмжиж зохих баганад тэмдэглэнэ.
- Эхийн жин өндрийг хэмжин биеийн жингийн индексийг (цаашид БЖИ гэх) тооцоолно.

Хэрэв эх жирэмслэнгүүтээ хяналтад очсон бол жинг үзэж доорх томъёог хэрэглэнэ. Хэрэв эх нь жирэмсний эхний 3 сард хяналтад ирээгүй бол жирэмслэхийн өмнө биеийн жин хэд байсныг асууна.

36 настай эмэгтэй жирэмслээд 1 сар болж байгаа. Одоо өндөр нь 1,54 м жин нь 50 кг байвал, $BЖИ=Жин\ кг/өндөр^2\ м=50/(1,54)^2=21$

Хүснэгт 1. Биеийн жин нэмэгдэх зохистой хэмжээ

Жирэмсний хугацаа	Нэмэгдвэл зохих жин
Эхний 3 сар	300-340г / долоо хоногт
Дунд 3 сар	350-400г/ долоо хоногт
Сүүлийн 3 сар	300-320г/ долоо хоногт

ЭХЭМД-ийн жирэмсэн үеийн зөвлөгөөнүүдийг уншиж, өөртөө илэрч буй шинж тэмдгүүдийг тогтмол хянаж байхыг эхэд сайтар хэлж зааж өгөх ба эхийн амрах байр болон амаржих газрын талаар эхэд зөвлөнө.

Эхийн жирэмсэн үеийн зөвлөгөөнүүд

Энэ хэсэг нь жирэмсэн эмэгтэй өөрийнхөө болон хэвлий дэх хүүхдийнхээ эрүүл мэндэд хэрхэн анхаарах зөвлөгөө юм. Энд жирэмсний хяналт, төмрийн бэлдмэл уух, хоол хүнс болон жирэмсний хугацаанд биед илрэх хэвийн болон эмгэг өөрчлөлтүүдийн талаарх мэдээллүүдийг оруулсан. Эдгээр заавар зөвлөгөө нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний заавар удирдамжуудын дагуу байгаа болно.

Анхан шатны эрүүл мэндийн ажилтнууд баг, өрх, сумын жирэмсэн эмэгтэйг хяналтад аль болох эрт оруулах талаар идэвхтэй ажиллах хэрэгтэй.

Жирэмсэн эмэгтэй жирэмсний хугацаандаа 6-аас доошгүй удаа хяналтад үзүүлсэн байх ёстой. Эрсдэлтэй жирэмсэн болон эрүүл мэндийн асуудалтай эхчүүдийг 8-аас доошгүй удаа үзэх хэрэгтэй.

Жирэмсний хяналт

Үзлэг 1. Эмэгтэй жирэмсний эхний 3 сард жирэмсэн болсноо мэдмэгц аль болох түргэн эмчийн хяналтад орох нь чухал юм. Анхны үзлэгээр жирэмсэн эхэд жирэмсэн үеийн оношилгоо, зөвлөгөө, ийлдсийн шинжилгээ, ургийн хэвийн бус байдлыг илрүүлэх болон БЗДХ-ын шинжилгээ, эхээс урагт ХДХВ-ын халдвар дамжих эрсдэлийн талаар зөвлөгөө өгнө.

Үзлэг 2. Хоёр дахь 3 сард эхийн эрүүл мэндийн байдал ба ургийн хэвийн өсөлтийг шалгана. Зайлшгүй шаардлагатай шинжилгээнүүдийг хийнэ.

Үзлэг 3 ба 4. Жирэмсний сүүлийн 3 саруудад ургийн хөгжил болон эхийн эрүүл мэндийг үзэж шинжилнэ.

Үзлэг 5. 32 долоо хоногтойд хэт авиан шинжилгээ, цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, сүрьеэ илрүүлэх асуумж болон бусад заалтаар шинжилгээнүүд хийнэ. Жирэмсний хожуу хордлого үүсэж болох, түүнээс сэргийлэх тухай зөвлөнө.

Үзлэг 6. 36 долоо хоногтойд хэт авиан шинжилгээ, шаардлагатай бол бусад шинжилгээ хийнэ. Биеийн үзлэг хийж, ургийн байрлал, янз, түрүүлсэн хэсгийг тодорхойлно. Ургийн зүрхний цохилтыг сонсоно.

Хяналтад ирэх бүрт ерөнхий үзлэг ба зайлшгүй шинжилгээ хийх ёстой гэдгийг эхэд сайтар ойлгуулах нь чухал.

Зөвхөн хэт авиан шинжилгээ хангалтгүй.

Төмрийн бэлдмэл ба фолийн хүчил

Төмрийн бэлдмэл уухад зарим үед дотор эвгүйрэх, гүйлгэх гэх мэтийн сөрөг нөлөө гарч болзошгүй талаар эхэд ойлгуулж ногоо жимс идэж, ус их уух нь төмрийн бэлдмэлийн энэхүү сөрөг нөлөөг багасгах бөгөөд хэдэн долоо хоногийн дараа энэ нөлөө нь аяндаа арилна гэдгийг хэлж өгнө.

Төмрийн бэлдмэлийг оройд тодорхой цагт уух ба сүү, цай, кофегоор даруулж ууж болохгүй. Цай кофенд агуулагддаг танин гэдэг бодис нь төмрийн шимэгдэлтийг сааруулдаг.

Жирэмсний эхний 3-5 долоо хоног буюу ургийн тархи нугас бүрэлдэх үед фолийн хүчлийг уух нь төрөлхийн гаж хөгжил, нугасны ивэрхий үүсэх эрсдэлийг багасгадаг талаар жирэмсэн эмэгтэйд сайтар ойлгуулах хэрэгтэй. Фолийн хүчил нь ногоон ургамал ба хүчиллэг жимсэнд агуулагддаг бөгөөд төмрийн шимэгдэлтийг сайжруулдаг.

Жирэмсэн эхийн хоол тэжээлийн зөвлөгөө

Жирэмсэн эмэгтэй тэжээллэг хоол хүнс идэж ууж байхад онцгой анхаарна. Энэхүү гарын авлагад дурдсан бүх төрлийн хоол хүнсийг идэхийг эхэд зөвлөөрэй.

Төмрөөр баялаг мах, загас, эрдэнэшиш, төмс гэх мэт хоол хүнсийг хэрэглэх нь цус багадалтаас сэргийлэх бол С аминдэмээр баялаг ногоо жимс идэх нь биед орсон төмрийг шимэгдүүлж, биеийн эд, эрхтнийг бүрэлдэхэд тусална. Өндөг, сүү, загас зэрэг нь биеийн араг яс, шүдийг бэхжүүлэхэд тусална.

Хоол тэжээлийн асуудалтай жирэмсэн эмэгтэйчүүдэд дараах чиглэлээр зөвлөгөө өгөх шаардлагатай.

Жирэмсний хордлого: Өдөрт бага хэмжээтэй өөртөө тохирсон хоол сонгож идэх

Хоол шингэхгүй удаж, цатгалдах: Өдөрт бага багаар идэх ба унтахын өмнө их идэхгүй байх, Удаан зажилж босоо байрлалд идэх

Өтгөн хатах: Ус их ууж эслэг ихтэй ногоо, шинэ жимс гэх мэт хоол хүнс идэх

Бөөлжих: Мах гэх мэт элдэв үнэртэй хүнснээс зайлхийх, цагаан будаа, гоймон, талх, төмс гэх мэт хоол хүнс идэх нь зүйтэй. Өглөө аяга бүлээн ус, цай, талх, боов зэргийг идэж болно.

Шөрмөс татах: Сүү, цагаан идээ, загас, гүнжидийн тос гэх мэтийн кальциар баялаг хоол хүнс хэрэглэнэ. Чухал гэж үзвэл кальци ба Д аминдэмийн нэмэлтийг эмчийн заавраар хэрэглэнэ.

Жирэмсэн эмэгтэйн ажил ба ажлын байр

Хүнд нөхцөлд, удаан хугацаагаар чийгтэй, тоостой орчинд ажилладаг жирэмсэн эмэгтэйчүүдэд өөрийгөө хамгаалах талаарх зөвлөх хэрэгтэй. Жирэмсэн эмэгтэйчүүд шүршдэг шавжны хор, химийн хортой бодистой ажиллаж болохгүй. Ажил хийдэг эмэгтэйчүүд амаржихаас 2 сарын өмнө жирэмсний амралтаа авах хэрэгтэй. Тэдэнд амаржсаныхаа дараах амралтыг урт байлгах гэж нөөцлөх хэрэггүй, учир нь амаржихын өмнөх амралт эх ургийн аюулгүй байдалд маш чухал гэдгийг тайлбарлаж зөвлөх хэрэгтэй.

Эрүүл ахуй

Эрүүл мэндийн ажилтан жирэмсэн эмэгтэйн биеийн болон бэлгийн эрүүл ахуй, ариун цэврийн талаар зөвлөгөө өгнө. Жирэмсний сүүлийн саруудад хөхөө арчлах талаар зөвлөж, хөхний толгой хэвийн биш бол амаржсаны дараа хүүхдээ хөхүүлэх талаар мэргэжлийн эмчийн зөвлөгөөнд илгээнэ.

Жирэмсэн үед бэлгийн амьдралаа хэрхэн зохицуулах талаар эмэгтэйд ичээж сандруулахгүйгээр эелдгээр зөвлөгөө өгнө.

Гэр бүлийнхний дэмжлэг

Эмэгтэй хүнд жирэмсэн, амаржих, амаржсаны дараах бүхий л үед эр нөхрийн түшиг, дэмжлэг асар чухал байдаг.

Эмэгтэйд жирэмсний хяналтад үзүүлэхэд нь нөхөртэйгээ ирэхийг зөвлөж хоёуланд нь ЭХЭМД-ийг хэрхэн ашиглах талаар зааж хэлж өгнө.

Мөн өрх, сум, багийн эмч сувилагч гэрээр эргэхдээ гэр бүлийн гишүүдэд ЭХЭМД-ийг танилцуулж, хөх хуудсуудыг хэрхэн ашиглах талаар заана.

Амаржихад бэлтгэх

Эмнэлгээс алслагдсан байрлалд амьдардаг эхчүүд амаржихаас 7-10 хоногийн өмнө эхийн амрах байранд ирж байрлахын чухлыг ойлгуулна.

Мөн жирэмсэн үеийн аюултай шинжүүдийг нэг бүрчлэн хэлж ойлгоцыг нь шалгана. Хэдийд эхийн амрах байр болон амаржих газарт очих талаар тодорхой зааварлана.

ЭХЭМД-ийн жирэмсэн үеийн зөвлөгөө мэдээллийг сайтар уншихыг эхэд зөвлөх ба эх ойлгосон эсэхийг асууж магадлана.

Эхийн амаржих хугацааг тодорхойлохдоо:

Сүүлийн биеийн юм ирсэн эхний өдрийг санаж байвал 7-г нэмнэ.

Сүүлийн биеийн юм ирсэн сар дээр 9-ийг нэмнэ.

Жишээ нь: Одмаагийн биеийн юм хамгийн сүүлд 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр ирсэн бол амаржих хугацаа нь:

Өдөр: 18-ны өдөр +7=25
Сар: 1-р сар+9 сар=10 сар
Эндээс Одмаа 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдөр амаржина гэж тооцоолно.

Жирэмсэн эмэгтэйд хийх ерөнхий үзлэг

- Биеийн өндрийг эхний үзлэгээр хэмжинэ
- Биеийн жинг үзлэг бүрд хэмжинэ
- Арьс салстыг шалгаж цус багадалт хаван байгаа эсэхийг үзнэ
- Цусны даралтыг хэмжинэ
- Зүрх, уушгийг үзнэ
- Хөхийг үзнэ
- Хэрэв бусад эрхтэн тогтолцооны талаас асуудалтай бол үзнэ.

Жирэмсний хяналт

А. Эхний гурван сар

- Хэвлийг тэмтэрч, умайн ёроолыг тодорхойлно.
- Хэвлийн язралтыг шалгана.
- Нөхөн үржихүйн замын халдварын сэжигтэй бол толь тавьж умайн амсрыг шалгана.
- Жирэмсэн гэдэг нь эргэлзээтэй тохиолдолд л зөвхөн оношийг тодруулах зорилгоор дотуур үзлэг хийнэ.

Б. Хоёр дахь гурван сар

- Умайн ёроолын өндрийг хэмжинэ
- Хэрэв умайн ёроол хүйсийн орчим байвал ургийн зүрхний цохилтыг шалгана.
- Ургийн хөдөлгөөн, тоо, ураг орчмын усны байдлыг шалгана
- Нөхөн үржихүйн замын халдварын сэжигтэй бол умайн хүзүүг шалгах ба дотуур үзлэг хийж болно.

В. Гурав дахь гурван сар

- Энэ үед жирэмсний үзлэгийг сард нэг удаа хийнэ.
- Умайн өндөр ба хэвлийн тойргийг хэмжинэ.
- Ургийн байрлалыг тэмтэрнэ.
- Ургийн зүрхний цохилтыг шалгана.
- Төрөхөөс 1 сарын өмнө ургийн толгойн байрлалыг үнэлнэ.
- Ургийн хөдөлгөөн, ургийн тоо, ураг орчмын усыг шалгана.
- Унтаж байвал эхийг хажуугаар нь хэвтүүлж үзнэ. Хавантай бол 2 хөлийг дэрэн дээр байрлуулж үзнэ.
- Нөхөн үржихүйн замын халдварын сэжигтэй бол толь тавьж умайн хүзүүг шалгана.

Шаардлагатай шинжилгээнүүд:

- Шээсэнд уураг үзэх
- Гемоглобины сорил
- Бусад

ЭХЭМД-ийн хөх булантай хуудсуудад эцэг эх гэр, бүлийн гишүүдийн зайлшгүй мэдвэл зохих зөвлөгөөг оруулсан болно.

Жирэмсэн үеийн аюултай шинжүүдийн талаар эхчүүдийн хичээлээр болон зөвлөгөөнд ирэхэд нь тайлбарлаж дараах шинжүүд илэрвэл эмчид яаралтай хандах талаар ойлгуулна. Үүнд:

- Үтрээнээс цус алдах
- 38 хэмээс дээш халуурах
- Толгой хүчтэй өвдөх, нүд эрээлжлэх, цусны даралт 140/90-ээс ихсэх
- Нуруугаар байнга өвдөх
- Үтрээнээс их хэмжээний шингэн гарах
- Биеийн жин огцом нэмэгдэж, гар хөл шагай болон нүүрээр хавагнах,
- Гэнэт хэвлий, аарцгаар үргэлжлэн өвдөх
- Тогтмол дуншиж өвдөх (37 долоо хоногийн дотор, цагт 4-өөс доошгүй удаа)
- Ургийн хөдөлгөөн удаашрах болон хөдлөхөө болих гэх мэт.

Эрүүл мэндийн ажилтан, эмч сувилагчид нь гэр бүл, эцэг эхэд хөх булантай хуудсуудыг сайтар ойлгуулах нь чухал.

Эрүүл мэндийн ажилтнуудын (Өрх, сумын эмч сувилагч, багийн эмч, нийгмийн ажилтан) үйл ажиллагааны гол хэсэг нь гэр бүл, олон нийтийн хүүхэд асран хамгаалах мэдлэг, дадлыг сайжруулах юм. ЭХЭМД-ийг хүүхдийнхээ эрүүл мэнд, хөгжлийг дэмжихэд тогтмол ашигласнаар хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулж байгаа гэдгийг гэр бүлд ойлгуулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах хэрэгтэй. Эхчүүдэд дараах мэдээллийг заавал өгч ойлгоцыг асууж шалгана:

- Нярай хүүхдийн хүйсэн дээр ямар ч боолт наалт, даавуу тавьж болохгүй
- Нярайг төрөнгүүд эхийн хэвлий дээр нүцгэнээр тавих
- Нярайг төрсний дараах эхний нэг цагийн дотор амлуулах ба цаашид 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллохыг зөвлөх
- Нярайд К аминдэм ба нүдний урьдчилан сэргийлэлт хийсэн эсэхийг ээжид нь заавал мэдэгдэх
- Нярайд төрсний дараах 24 цагийн дотор БЦЖ, гепатит В, саагийн эсрэг вакцинуудыг хийж, ЭХЭМД-ийн “Нярай хүүхдийн үзлэг” гэсэн 2 хувь хуудсанд тэмдэглэх ёстой

3

ТӨРӨЛТИЙН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ

ЭХЭМД-ийн төрөлтийн талаарх тэмдэглэлийг амаржих газрын эмч, эх баригч бөглөх ба сумын ЭМТ-д төрсөн бол сумын эмч бөглөнө. Ингэхдээ амаржих газрын нэрийг заавал бичнэ. Жишээлбэл:

Амаржих гарын нэр: *Тэс сумын ЭМТ тасгийн дугаар 01.г.м.* Үүнд:

- Жирэмсний тээлтийн хугацаа
- Төрсөн он, сар, өдөр
- Төрөлт үргэлжилсэн хугацаа
- Ургийн байрлал: түрүүлсэн хэсгийг заавал тэмдэглэнэ
- Нярайн дугаар

Нярайн төрөх үеийн байдал гэсэн хэсэгт хэвийн, хүндрэлтэй, кесар хагалгаагаар гэх мэтээр тэмдэглэнэ.

Амаржих газрын эмч, эх баригч эмнэлгээс гарахад нь ЭХЭМД-ийг заавал шалгаж хуудасны холбогдох хэсгийг бөглөж өгнө.

Эх нярай хоёрыг гэртээ гарсны дараа 24-72 цагийн дотор өрх, сум, багийн эрүүл мэндийн ажилтан эргэж үзэх ба ингэхдээ “НЯРАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД ӨСӨЛТ, ХӨГЖИЛ” гэсэн хүснэгтэд хүүхдийн байдлыг тэмдэглэнэ. Шаардлагатай бол нэмэлт хуудсанд тэмдэглэл хийж дараагийн ирэлтийг товлон. Хүүхдийн төрсний гэрчилгээ авсан эсэхийг асууж тэмдэглэнэ.

Өрх сум, багийн эрүүл мэндийн ажилтан нь эх хүүхдийг амаржих газраас гарсны дараа эхний долоо хоногт 2 удаа, дараагийн долоо хоног бүрт 1 удаа гэрээр эргэж үзэж асаргааны талаар зөвлөгөө өгөх ба туршлагагүй эхэд хүүхдээ хэрхэн арчлахыг өөрөө хийж, зааж үзүүлнэ.

Эхийн хоол тэжээл, өдрийн дэглэм

Дөнгөж нярайлсан ээж шим тэжээллэг хоол хүнс идэх ба биеийн галбир алдах вий гэж хоолны дэглэм барьж болохгүй. Хоногт 8 цаг унтах ба өдөр унтах хэрэгтэй.

Умай агшиж өвдөх

Умай агшиж хүчтэй өвдөж байвал бүлээвтэр жин тавьж болно. Удаан үргэлжлэн хүчтэй өвдвөл мэргэжлийн эмчээс зөвлөгөө авах нь зүйтэй.

Хөхийг арчлах

Хэрэв хөхний суваг бөглөрч хөх зангирсан бол үрэвсэл үүсэхээс сэргийлж яаралтай ойр ойр хөхүүлэх, саах, соруулах зэрэг арга хэмжээ авна.

Хөдөлгөөн

Амаржсанаас хойш 6 цагийн дараагаас эх сууж болох ба нэг хоноход зөөлөн явж болно.

Гэр бүлийн гишүүд, ялангуяа эхэд ЭХЭМД-ийн хөх булантай хуудсыг хэрхэн уншиж тэмдэглэх талаар сайтар зааж ойлгуулна. (Ойлголтыг шалгаж ойлгоогүй буюу хайхрахгүй бол дахин тайлбарлаж өгнө). Эхний сараас дэвтрээ ашиглаж сурвал цаашид тогтмол тэмдэглэх дадал зуршилтай болох юм.

Эхийн сүүгээр хооллолт

Нярай хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох ба өдөр шөнийн алинд ч хүссэн үед нь хоногт 8-аас доошгүй удаа хөхүүлнэ. Эрүүл мэндийн ажилтан хүүхдийг хөхөө хөхөж байгааг ажиглангаа эх нь хөхүүлж чадахгүй бол зааж амлуулж өгнө.

Нүдний арчилгаа

- Хүүхдийн нүдийг арчлахын өмнө болон дараа гараа савандаж угаана.
- Чийгтэй цэвэр алчуураар нүдийг өдөр бүр цэвэрлэнэ.
- Ямар нэгэн нүдний дусаалга хэрэглэх шаардлагагүй.

Хүйг арчлах

Хүй цэвэр хуурай байх ёстой. Ямар нэгэн боолт тавих, битүү байлгах хэрэггүй. Хүйсний эргэн тойронд болон хүйсэнд угаагаагүй гараар хүрч болохгүй.

Арьсыг арчлах, биеийг угаах цэвэрлэх

- Хүүхдийн бөгс, нүүрийг өдөр бүр угаах ба бүхэлд нь усанд оруулах шаардлагагүй
- Усанд оруулахдаа гарын шууг дүрж үзэж усны бүлээнийг тохируулан оруулна. Салхи сийгэх газар болохгүй
- Хүүхдийн малгай, даавуу, цамцыг өдөр бүр, живхийг тухай бүр солино
- Хүүхдийн бугалга дээр сүрьеэгийн эсрэг вакцины сорви байгаа эсэхийг шалгаад байхгүй бол товлолын вакцинд очиж хийлгэх арга хэмжээг авна

4

ТӨРСНИЙ ДАРААХ 1-6 ДОЛОО ХОНОГТОЙД

ЭХИЙГ ХЯНАХ

- Эх өөрийн эрүүл мэндийн байдал, амралт, нойр, хоолны дэглэм, шээс, гэдэс ходоодны үйл ажиллагаагаа үнэлнэ. Бүгд хэвийн бол эхийг урамшуулж магтана
- Халуурах: Эхийн биеийн халуун 37 хэмээс дээш бол халуунтай гэж үзэж анхаарах хэрэгтэй. Халуурч буй шалтгааныг судална
- Хэвлийн доод хэсгээр өвдөлт илрэх: Өвдөлт нь байнга, хэвлийг дарахад илүү өвдөж байвал ноцтой гэж үзэж шинжилгээ хийх болон мэргэжлийн эмчид явуулж үзүүлнэ
- Үтрээнээс ялгадас гарах: Шавхарга бол төрсний дараах 7-10 хоногт гардаг. Энэ нь эхлээд их гарч байснаа өдөр өдрөөр багасдаг. Шавхарга нь бараан өнгөтэй, эвгүй үнэртэй бол эмчид заавал үзүүлэх хэрэгтэй
- А амин дэм: Эх амаржсаны дараах эхний 7 хоногт А амин дэм уугаагүй бол уулгана

ХҮҮХДИЙГ ХЯНАХ

Эхийн сүүгээр хооллох

- Хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллож байна уу,
- Хүссэн үедээ өдөр шөнийн аль ч үед хоногт 8 болон түүнээс олон удаа хөхөж байна уу, хөхөө зөв үмхэж байгаа эсэхийг шалгаж эхэд зааж зөвлөнө.

Арьс

Хүүхдийн хэвийн шарлалт нь төрсний дараа 2-3 дахь хоногтойгоос эхэлж, 10-14 хоногийн дараа арилдаг. Төрснөөс хойш 14 хоноход арьс нь шар байсаар байгаа бол шинжилгээ хийж үзнэ.

Хүй цөглөх

Ихэнх хүүхдийн хүй төрсний дараах 5-7 хоногт цөглөж унадаг. 10 хонож байхад хүй цөглөж унахгүй бол халдвар авсан болон ондоо шалтгаан байна гэж үзэж шинжилгээ хийж арга хэмжээ авна.

Ерөнхий биеийн байдал

Энэ үедээ хүүхэд суниах, дуу чимээнд сэрэх, ямар нэгэн зүйлийг ширтэх гэх мэт илрэл үзүүлдэг. Эцэг эх, гэр бүлийн гишүүдэд хүүхдийн рефлексүүдийг шалгах аргыг зааж өг.

Хүүхдэд эдгээр рефлекс илрэхгүй бол аймгийн нэгдсэн эмнэлэг болон дүүргийн ЭМТ-ийн холбогдох эмч мэргэжилтнүүдэд илгээж, оношилгоо үнэлгээ хийлгэх шаардлагатай.

Дархлаажуулалт

Хүүхдийг төрөнгүүт 24 цагийн дотор сүрьеэгийн эсрэг БЦЖ, халдварт саагийн эсрэг, В гепатитын эсрэг вакцинуудыг хийлгэсэн байх ёстой.

БЦЖ вакциныг төрсний дараах 1 сард багтаан заавал хийх хэрэгтэй.

Эх нярайг гэрээр эргэх

ЭХЭМД-ийн улаан булантай хуудсуудыг эрүүл мэндийн ажилтан бөглөнө. Амаржих газраас гарсны дараах эхний 24-72 цагийн дотор эх, нярайг гэрээр заавал эргэж үзэж, нярайн нэн шаардлагатай тусламж, асаргаа сувилгааны талаар зөвлөгөө өгнө. Үүнд: Хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох, хэрхэн хөхүүлэх, хуурайлах, угаах, дулаан байлгах болон хүүхдэд илрэх аюултай шинжүүдийн талаар сайтар хэлж ойлгуулна (Хүүхдийг нүүрээр нь доош харуулж хэвтүүлж болохгүй).

Эхэд нь шим тэжээллэг хоол идүүлж, тайван байлгах, хүүхдийн дэргэд тамхи татаж болохгүй, мөн ханиад томуутай хүмүүс болон тоос шороотой орчноос аль болох хол байлгаж, гэр орныг агааржуулах талаар зөвлөнө.

Дөнгөж төрсөн зарим нярай орчиндоо дасан зохицож эхлэх үедээ нэлээд уйлдаг ба ийм хүүхдийг “Тархины даралттай” гэж эцэг эхийг сандаргах болон стандартад байхгүй эм уулгах нь буруу юм.

Мөн хүүхдээ иргэний бүртгэл мэдээлэлд бүртгүүлж, төрсний гэрчилгээ авахыг гэр бүлд нь сануулаарай.

5

ХҮҮХДЭД БОДИТ ҮЗЛЭГ ХИЙХ

Үзлэг хийхдээ хүүхдийн ээж болон гэр бүлийн гишүүдээс байлцуулна.

Үзлэгийг голдуу зүрх, уушгиас эхлээд толгойноос хөл хүртэл үзэж үнэлэх ба төрөлхийн гаж хөгжлийн шинж байгаа эсэхийг сайтар шалгана.

Зүрх судасны тогтолцоо

Зүрх, уушгийг үнэлэхдээ хүүхдийг тайван уйлаагүй байхад үзлэг хийнэ.

Зүрхний авиа хамгийн тод сонсогдож байгаа байрлалыг олж тогтоосноор баруун байрлалтай гэдгийг үгүйсгэнэ. Зүрхний цохилт (Хэвийн: 100-160 /мин) ба хэмийг шалгана. Хэм нь тогтмол байх ёстой ба аортын цорго битүүрээгүй тохиолдолд ч хэм алдагдах нь төдийлөн нийтлэг биш байдаг. Төрсний дараах 24 цагийн дотор шуугиан сонсогдох нь артерийн цорготой холбоотой. Амаржих газар төрсний дараах 3 хоногт хүүхдийн зүрхийг өдөр бүр чагнаж, зүрхний шуугианыг үгүйсгэнэ. Гуяны судасны лугшилтыг шууны судасны лугшилттай харьцуулна. Гуяны судасны лугшилт сул, эсвэл удаан байвал аортын коарктац, эсвэл зүүн ховдлоос гадагшлах урсгалд бөглөрөл байгаа гэсэн үг. Төвийн хөхрөлт байвал зүрхний төрөлхийн гажиг, уушгины өвчин, үжил зэргийг сэжиглэнэ.

Амьсгалын тогтолцоо

Амьсгалын тогтолцоог үнэлэхдээ 1 минутын турш хүүхдийн амьсгалыг тоолно. 1 минутад 40-60 хүртэл бол хэвийн гэж үзнэ. Цээжний хэнхэрцгийг гаднаас ажиглахад 2 талд ижил хэмтэй, чагнуураар чагнахад уушгины авиа 2 талдаа ижил сонсогдоно. Хяхтнах, хамрын угалз сарталзах зэрэг нь амьсгалын хямралын шинж болно.

Толгой хүзүү

Гавлын гадна цусархаг хавдар кефалогематом элбэг тохиолддог ба энэ үед гавлын яс ба гадарга хальсны завсар цус хурж хавдаж хөөх бөгөөд заадсуудын завсраар ордоггүй. Кефалогематом нь аажим багассаар хэдэн сарын дараа арилдаг. Энэ нь нэг талын болон 2 талын зулайн ясанд, заримдаа дагз орчимд үүсдэг.

Толгойн хэмжээ ба хэлбэрээр нь төрөлхийн гидроцефали буюу тархи усжилтыг эрт илрүүлэх боломтой.

Удам зүйн зарим хам шинжүүдийг гавал нүүрний гаж хөгжлөөр илрүүлэх боломжтой. Нүүр царайны 2 талд жигд эсэх, хэвийн хөгжил, доод эрүү, тагнай, чихний гадна суваг зэргийг үзнэ.

Нүдийг төрсний маргааш шалгах нь хялбар. Учир нь төрөх явцад хүүхдийн зовхи хавагнадаг. Нүдэнд улаан рефлекс байхгүй бол глауком, катаракт болон ретинобластом байж болзошгүй.

Чихний байрлал доор байх нь 21 дүгээр хромосомын гурвал (Down syndrome) байж болзошгүйг илтгэнэ. Чих ба гадна сувгийн гаж хөгжил байвал удамшлын өвчнийг сэжиглэх хэрэгтэй. Эмч чихний гадна дэлбэн, хэлбэр зэргийг сайн ажиглах хэрэгтэй. Заримдаа энэ нь дүлий болон бөөрний гаж хөгжилтэй холбоотой байдаг.

Зарим нярай төрөхдөө буйлны хавдартай (эпулис) төрдөг ба том хэмжээтэй хавдар хүүхдийг хооллох ба амьсгалахад бэрхшээл учруулдаг. Үүнийг авах ба дахин ургадаггүй.

Зарим нярай шүдтэй төрдөг, гэхдээ энэ нь сурвалжгүй тул шүдний эмч сугалж авна.

Хэвлий ба аарцаг

Хэвлий дугуй хэлбэртэй 2 талдаа жигд хэмтэй байна. Ургийн хөгжлийн үед өрцөнд цоорхой үүссэнээс цээжний хөндий рүү хэвлийн хөндийн эрхтнүүд чихэлдэн орж амьсгал хямралын хам шинж үүсэх эрсдэлтэй. Хэвлий 2 талдаа жигд биш бол хэвлийд ямар нэг үүсвэр байж болзошгүй. Элэг хавирганы нумаас доош 1-2 см тэмтрэгдэх нь хэвийн. Хүйн ивэрхий хүйн цагираг булчингийн сул хөгжлөөс үүдэлтэй бөгөөд элбэг тохиолддог боловч бараг мэдэгддэггүй.

Хөвгүүдэд шодойг шалгаж гипоспади болон эписпади байгаа эсэхийг үзнэ. Мөн төмсөг нь хуухнагтаа буусан эсэхийг шалгана. Хуухнаг нь хавантай бол гидроцел, цавины ивэрхий зэргийг сэжиглэнэ.

Охидод бэлгийн уруулыг үзнэ. Үтрээнээс шингэн салс, цусархаг ялгас ялгарах нь хэвийн. Хоёрдмол эрхтэн байх нь ховор тохиолддог эмгэг юм.


Бэлэг эрхтнийг хэвийн эсэхийг ажиглана. Клайнфелтер, Тернерийн хам шинж сэжиглэвэл дотоод шүүрлийн булчирхайн ба удамзүйн эмчид үзүүлнэ.

Яс булчингийн тогтолцоо

Мөчдийн хэлбэр муруйж тахийсан, хөгжил дутуу гэх мэтийг шалгана. Төрөх үеийн гэмтлээс үүдэлтэй шууны мэдрэлийн саажилт үүсч улмаар гарын хөдөлгөөн хязгаарлагдмал болдог.

Нуруунд нугасны ивэрхий болон нурууны менингомиелоцеле зэргийг үгүйсгэнэ.

Түнхний үений мултрал ба дутуу хөгжлийг үгүйсгэнэ. Ингэхдээ ургийн хөндлөн байрлал, ихэр, болон гэр бүлийн түүхийг судалж үзнэ. Эрсдэлт хүчин зүйлүүдийг тооцох нь чухал. Гэрийн нөхцөлд Барлоу, Ортолани сорилуудыг ашиглана.



Зураг 1. Барлоу сорил ба Ортолани сорил

Барлоу сорил:

Хүүхдийг тайван үед дээш харуулж хэвтүүлэн 2 хөлийг түнхний үеэр нугалан 90° дээш өргөн түнхний тэнхлэгт дарахад хэрэв мултрал байвал дунд чөмөгний ясны толгой сүүжний хонхроос мултрах чимээ гарах ба гарт мэдрэгдэж байвал мултралыг сэжиглэнэ.

Ортолани сорил:

Хүүхдийг тайван үед дээш харуулан хэвтүүлээд 2 хөлийн түнхний болон өвдөгний үеийг 90 градус нугалж, 2 хөлийг ээлжлэн болгоомжтой алцайлгахад дунд чөмөгний ясны толгой сүүжний хонхорт орох чимээ гарах ба гарт мэдрэгдэж байвал мултралыг сэжиглэнэ.

Нярайн дуу авиа болон сэргэлэн цовоо байдал, үе мөчдийн хөдөлгөөн, хариу үйлдлүүдийг шалгаж үнэлнэ. Нярайн Моро, хөхөх, хайх рефлексүүдийг шалгаж үзнэ. Ингэхдээ:

- Моро рефлекс: Хүүхдийг орноос нь хөндий дээш аажим өргөөд гэнэт буулгахад хүүхэд гар хуруугаа сарвасхийлгэн тэнийлгэж, түнхний үеэр агийж уйлна.
- Хайх рефлекс: Нярайн хацар болон завьжны орчим хуруугаар дарахад хүүхэд толгойгоо урагш сунгаж амаа ангайж хуруунд хүрэх гэж оролдоно.
- Хөхөх рефлекс: Соосог болон бээлийтэй хурууг хөхүүлж рефлексийг шалгана.

Эдгээр рефлекс нь 3-4 сартайд арилдаг захын мэдрэлийн тогтолцооны хэвийн үзэгдэл юм.

Арьс

Нярайн арьс голдуу улаавтар бөгөөд төрсний дараах хэдэн цагт хуруу хумс хөхөлбий өнгөтэй байдаг. 24 долоо хоногоос дээш тээлтийн настай нярайд бүх бие нь Vernix caseosa хэмээх бүрээстэй байдаг. Хуурайшилт болон гуужилт өдөртөө явагддаг ба ялангуяа бугалга, шагайгаар тод илэрдэг. Нүүрээр түрүүлсэн төрөлт зэрэг төрөх үеийн гэмтсэн хэсгээр улаан цэгэн тууралт ажиглагддаг. Нилэнхүй

цусархаг тууралт байвал тромбоцитопени буюу ялтсан эсийн цөөрлийг шинжлэх шаардлагатай.

Ихэнх нярайд erythema toxicum буюу улаан суурь дээр цагаан ба шарангуй өнгийн толгойтой тууралт ажиглагддаг. Энэ тууралт нь төрсний дараах 24 цагийн дараа гарч биеэр тархан 2 долоо хоног орчим үргэлжилдэг.

Нярайн тандалт шинжилгээ буюу нярайн скрининг

Монгол Улсад 2013 оноос нярайг төрсний дараах эхний хоногуудад түнхний дисплази, мултрал, сонсгол, харааны, бодисын солилцооны эмгэгүүдийн тандалт шинжилгээнд хамруулах бодлогыг хэрэгжүүлж байна.

Нярайн шарлалтыг 14 хоногоос дээш үргэлжилбэл, билирубинийг тусгай хэмжигчээр арьсанд үзэх, эсвэл цусыг авч ийлдсэнд үздэг.

Нярайн зүрхний төрөлхийн өвчин байгаа эсэхийг пульс оксиметрээр үзэх боломжтой.

24 цагаас дээш настай нярайд дараах үзүүлэлтүүд эерэг бол хүүхдэд рентген, зүрхний хэт авиан болон цахилгаан бичлэг хийж, хүүхдийн зүрхний эмчид үзүүлэх шаардлагатай.

- O_2 -ийн ханамж $< 90\%$.
- Баруун гар хөлд O_2 ханамж 1 цагийн зайтай 3 удаа үзэхэд $< 95\%$ бол.
- Баруун гар хөлд O_2 ханамж 1 цагийн зайтай 3 удаа үзэхэд үнэмлэхүй ялгаа нь $> 3\%$

Толгойн тойрог хэмжих

Шинэ төрсөн нярай хүүхдийн толгойн тойрог 30.31 ± 1.85 байна. Эхний 3 сард сар бүр 3 см-ээр нэмэгдэх ба цаашид удааширна

Хүүхэд 1 нас хүрэхэд толгойн тойрог 45 ± 1.5 см. 2-3 настайд жилд 2 см нэмэгдэнэ. 5 настай хүүхдийн толгойн тойрог 49-50 см байна.

Цээжний тойрог

Дөнгөж төрсөн гүйцэд нярайн цээжний тойрог толгойн тойргоос жижиг, 30 см орчим байна. Эхний сард маш түргэн нэмэгдээд аажим удааширдаг. Хүүхэд 1 настайд цээжний тойрог $45 \text{ см} \pm 1.5$ болно. 2-3 насанд цээжний тойрог толгойнхтой тэнцүү болж цаашдаа цээжний тойрог нь толгойнхоос түргэн нэмэгдэнэ.

ЭХЭМД-ийн “Нярай хүүхдийн үзлэг” 2 хувь маягтыг төрсний дараах 7 хоногт эмч бөглөж тэмдэглэн, 1 хувийг ЭМТ-д хадгална.

6

ХҮҮХДЭД БОДИТ ҮЗЛЭГ ХИЙХ

6.1 Хүүхдийг жинлэх

Хүүхдийг жинлэснээр нь хүүхэд хэрхэн өсөж байгааг мэдэх болон аливаа эрсдэлт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хооллолт, асаргаанд гарсан өөрчлөлт хэрхэн нөлөөлж байгааг олж мэдэхэд чухал ач холбогдолтой. Иймд хүүхдийн биеийн жингийн үнэлгээг тогтмол хийх нь чухал шаардлагатайг хүүхдийн эцэг эхэд ойлгуулах хэрэгтэй.

6.1.1 Хүүхдийг эхэд нь тэврүүлэн жинлэх

Хүүхэд хоёр нас хүрээгүй эсвэл ганцаараа зогсож чадахгүй бол багцын жинг хэрэглэнэ. Нойтон живх болон гутал, жийнсэн хувцас нь 500 граммаар илүү жинлэгдэх боломжтой. Бага насны хүүхдийг заавал нүцгэн жинлэх хэрэгтэй. Ингэхдээ жинлэх хүртэл өлгийд нь ороож дулаан байлгана. Багцлан жинлэх явцад ээжид нь яах ёстойг тайлбарлан, ойлгуулж өгнө. Ээж нь хүүхдээ тэвэрч, жинлэж дуусах хүртэл жинлүүр дээр зогсох ёстойг онцолж хэлнэ. (Ээж нь боломжгүй бол хэн нэгнээр туслуулна) Жинлэхдээ:


- Ээж нь гутлаа тайлж, жинлүүр дээр зогсоод жинлүүлнэ. Ингэхдээ жинлүүрийн асаах цонх болон дэлгэцийг халхлах урт хормойтой хувцас өмссөн бол тайлах эсвэл хормойгоо шуух хэрэгтэй.
- Ээжийн жин жинлүүрийн дэлгэцэн дээр гарсны дараа ч жинлүүр дээрээс буулгүй зогсож байхыг сануулна. Жинлүүрийн жингийн заалтыг эргэж тэглэнэ.
- Дараа нь хүүхдийг ээжид нь өгч тэврүүлнэ.
- Хүүхдийн биеийн жин жинлүүрийн дэлгэц дээр гарч ирнэ.
- Хүүхдийн биеийн жинг тэмдэглэнэ.



Зураг 2. Жингээ асаана



Зураг 3. Хүүхдийг авч эхийг жин дээр зогсохыг хүснэ



Зураг 4. Эхийг буулгахгүйгээр жинг тэглэнэ.



Зураг 5. Хүүхдийг эхэд тэврүүлэхэд зөвхөн хүүхдийн жин гарна.

6.1.2 Хүүхдийг ганцааранг нь жинлэх


Хүүхэд 2-оос дээш настай, эсвэл бие даан зогсож чаддаг бол түүнийг ганцааранг нь зогсоож жинлэнэ. Хүүхдэд жин дээр ганцаар удаан зогсох хэрэгтэйг тайлбарлана. Хүүхэдтэй эелдэг, зөөлөн харилцах хэрэгтэй.

Хүүхдийн гадуур хувцсыг тайлна. Хүүхдийн хувцсыг тайлснаар үнэн зөв жин гарах болно гэдгийг эцэг эх, асран хамгаалагчид тайлбарлана. Туслагчийг хүүхдийн гутал, гадуур хувцсыг тайлахад туслуул. Том хүүхдийг жинлэхдээ хувцсыг бүрэн тайлахыг хичээх бөгөөд дотуур хувцсыг үлдээж болно. Хүүхдийн хувцсыг тайлахад орчин нь хүйтэн, эсвэл хүүхэд хувцсаа тайлахаас эрс татгалзаж байвал хүүхдийг хувцастай нь жинлээд ЭХЭМД-т хувцастай байсныг нь тэмдэглэнэ. Хэрэв эцэг эхийн хандлага, орчин нь хүүхдийн хувцсыг тайлахад тааламжгүй байвал хувцсыг нь аль болох нимгэлнэ. Хүүхдийг жинлэсний дараа түүний өндөр буюу уртыг хэмжих учраас хүүхдийг уурлуулахгүй байх нь чухал.

Хүүхдийг жинлэхдээ:

- Жинлүүрийг асаагаад, асаах цонхыг секунд орчим хугацаатай халхал. Дэлгэцэн дээр 0.0 тоо гарахад жинлэхэд бэлэн болно
- Хүүхдийг жинлүүрийн голд цэх зогсооно. Хөлийн тавхайн зураг байвал тэр хэсэгт гишгүүлээд, дэлгэцэн дээр жин гарах хүртэл зогсож байхыг анхааруулна
- Хүүхдийн жинг хамгийн ойр 100 грамм руу шилжүүлэн тооцож, тэмдэглэнэ
- Хэрэв хүүхэд жинлүүр дээрээс буух юмуу тогтвортой зогсож чадахгүй бол багцлан жинлэх аргаар жинлээрэй

6.2 Хүүхдийн өндөр/уртыг хэмжихэд бэлтгэх



Зураг 6. Хүүхдийн урт/ өндөр хэмжих самбар


Сайн чанарын урт/өндөр хэмжигч самбар нь зөөлөн, чийгний хамгаалалттай (өнгөлгөөтэй) модоор хийгдсэн байна. Босоо болон хэвтээ хэсгүүдийн уулзвар нь тэгш өнцөг үүсгэн бат бөх холбогдсон байх хэрэгтэй. Хөдөлгөөнт тавцант хэсэг нь уртыг хэмжих үед хөлийн тавцан, өндрийг хэмжих үед толгойн тавцангийн үүрэг гүйцэтгэнэ. Самбарын ирмэгээр босоо чиглэлээр хэмжилтийн туузан метрийг бөх нааж байрлуулсан байдаг ба хөдөлгөөнт тавцангаар туузан метрийн тэмдэглэгээ гэмтэх, бүдгэрч арилахаас болгоомжлох хэрэгтэй.

Хүүхдийн нас болон эгц босоо зогсож чадах эсэхээс хамаарч урт эсвэл өндрийг хэмжинэ. Хэвтээ байдалд нурууны уртыг, эгц босоо зогсоо байрлалд нурууны өндрийг хэмждэг.

2 хүртэлх насны хүүхдийг хэвтүүлж нурууны уртыг хэмжинэ. 2 ба түүнээс дээш насны, зогсож чадах хүүхдийг эгц босоо зогсоож нурууны өндрийг хэмжинэ.

Эгц босоо зогсоож өндрийг хэмжихэд хэвтүүлж уртыг хэмжсэнээс тогтмол 0.7 см-ээр бага гардаг. Иймээс хэмжилт хийхдээ дараах байдлаар тооцоолно.


- 2 хүртэлх насны хүүхдийг хэвтээ байрлалд уртыг хэмжих буюу эгц босоо байдалд өндрийг хэмжсэн бол 0.7 см-ийг нэмж уртын хэмжээтэй тэнцүүлнэ.
- 2 ба түүнээс дээш насны боловч зогсож чадахгүй хүүхдийг хэвтээ байрлалд уртыг хэмжээд 0.7 см-ийг хасаж тооцоолно.




Зураг 7. Хүүхдийн өндрийг хэмжих зөв байрлал




Зураг 8. Хүүхдийн уртыг хэмжих зөв байрлал




Зураг 9. Толгойг толгойн тавцанд тулгана



Зураг 10. Толгойн зөв байрлал



Зураг 11. Хөлийн тавцанд өсгийг тулгана



Зураг 12. Хөлийн буруу байрлал

Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн өсөлтийн хүснэгтүүд ЭХЭМД-ийн сүүлийн хуудсуудад байдаг. Хүүхдийн хүйсэд суурилсан тохирох Өсөлтийн хүснэгтийг сонго. Эрэгтэй хүүхдийнх цэнхэр, эмэгтэй хүүхдийнх ягаан дэвсгэртэй байдаг. Дараа нь хүүхдийн насанд тохирсон гурван төрлийн хүснэгтийг сонго. Хоол тэжээлийн байдлын үзүүлэлтүүдийг сонгосон хүснэгтүүд дээр цэгээр тэмдэглэнэ. Үзүүлэлтүүдийг цэглэн тэмдэглэхийн тулд хүснэгтэд хамаатай зарим нэршлийг ойлгох хэрэгтэй.


Х тэнхлэг: Хүснэгтийн доод хэсэг дэх хэвтээ лавлагаа шугам. ЭХЭМД-т зарим хүснэгтийн Х тэнхлэг нь насыг заах ба заримд нь урт/өндрийг заана.

У тэнхлэг: Хүснэгтийн зүүн тал дахь босоо лавлагаа шугам. ЭХЭМД-т хүснэгтийн У тэнхлэг нь урт/өндөр эсвэл жинг заана.

Цэгэн тэмдэг: Хүснэгт дэх цэглэсэн тэмдэг нь Х тэнхлэг дэх хэмжилтээс (Жишээ нь: нас) татсан шугам ба У тэнхлэг дэх (Жишээ нь: жин) хэмжилтээс татсан шугамын огтлолцол дээр байрлана.

Доорх хүснэгтэд нас (Сар, эсвэл долоо хоног) Х тэнхлэг дээр, жин килограммаар У тэнхлэг дээр байна. 6 долоо хоногтой хүүгийн биеийн жин 5 кг дээр цэгээр тэмдэглэгдсэн байна. Хүснэгт дээрх муруй шугам нь лавлагаа шугамууд бөгөөд цэгэн тэмдэглэгээг унших, хандлагыг ойлгоход тусална.

*Хүснэгт 2. Эрэгтэй хүүхдийн Жин насны хүснэгт
Төрснөөс хойш 6 сар хүртэл (z-оноогоор)*



6.3 Урт/өндөр насны үзүүлэлтийг тэмдэглэхдээ:

Х тэнхлэг дээр хүүхдийн насыг тэмдэглэхдээ: Бүтэн сарыг босоо шугаманд (Босоо шугамын завсраар биш) тэмдэглэнэ. Жишээ нь: Хэрэв хүүхдийн нас 5 нас 7 сартай бол (6 сар хүрээгүй гэсэн үг) цэгэн тэмдэглэгээ зөвхөн 5 сарын шугаман дээр (5 ба 6 сарын шугамын завсраар биш) тэмдэглэнэ.

У тэнхлэг дээр хүүхдийн урт/өндрийг тэмдэглэхдээ: Урт буюу өндрийг хэвтээ шугаман дээр тэмдэглэхдээ аль болох нарийвчлалтайгаар тэмдэглэхийг хичээ. Жишээ нь: Хэрэв хэмжилт 60.5 см бол хэвтээ шугамуудын завсраар тэмдэглэгдэнэ.

2 ба түүнээс дээш хяналтад хамрагдалтын цэгэн тэмдэглэгээг хооронд нь зураасаар холбож өсөлтийн хандлагыг ажиглана.

6.4 Жин насны үзүүлэлтийг цэглэн тэмдэглэх

Жин насны үзүүлэлт нь тухайн хүүхдийн насанд биеийн жинг нь харьцуулсан харьцаа юм. Энэ үзүүлэлтийг хүүхдийг тураалтай, хүнд тураалтай эсэхийг үнэлэхэд ашиглах ч, хүүхдийг жингийн илүүдэлтэй эсвэл таргалалттай гэж ангилахад ашигладаггүй. Жин бол хэмжихэд амархан, байнга ашиглагддаг үзүүлэлт боловч хүүхдийн насыг нарийвчлан тодорхойлох боломжгүй нөхцөлд хэрэглэхэд төвөгтэй.

АНХААРАХ: Хэрэв хүүхдийн хоёр хөл хавантай бол шингэний хуримтлал хүүхдийн жинг нэмэх ба энэ нь хүүхдийг маш бага жинтэй байгааг далдалдаг. Хавантай хүүхдийн жин нас, жин урт/өндрийн үзүүлэлтийг өсөлтийн хүснэгт дээр нь тэмдэглэхдээ энэ хүүхэд хавантай байсан гэдгийг нь заавал (Цэгэн тэмдэглэгээний ойролцоо) тэмдэглэнэ. Хоёр хөлдөө хавантай хүүхдийг нь хоол тэжээлийн хүнд хэлбэрийн дутагдал байна гэж үзээд тусгай эмчилгээнд яаралтай, шууд хамруулна.

6.5 Өсөлтийн хүснэгт дэх хандлагыг тайлбарлах нь

Өсөлтийн муруй нь хүүхдийн тогтмол сайн өсөж байгаа эсэхийг харуулахаас гадна өсөлтийн асуудал байгаа эсэх, хэрэв байвал эрсдэл бэрхшээлийг тогтоож чаддаг. Хэвийн өсөж байгаа хүүхдийн өсөлтийн муруй нь ерөнхийдөө голч шугамтай зэрэгцээ Z-онооны шугамын дагуу өгсдөг. Ихэнх хүүхдийн өсөлтийн муруй нь Z-онооны шугам ба дундаж шугамын завсар ерөнхийдөө параллель маягаар өгсдөг. Өсөлтийн хүснэгт дээр ажиллах явцад дараах асуудал буюу эрсдэл гарвал анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Хүүхдийн өсөлтийн муруй Z-онооны шугамтай огтлолцох
- Хүүхдийн өсөлтийн муруй огцом өгсөх буюу уруудах
- Хүүхдийн өсөлтийн муруй тэгширвэл жин ба өндөр нэмэгдэхгүй байна гэж ойлгоно.

Z-онооны шугамтай огтлолцох

Өсөлтийн муруй нь Z-онооны шугамтай огтлолцох нь эрсдэл учирч болзошгүйг заадаг. Тайлбар нь эрсдэл хаанаас эхэлж байгаа болон хаашаа чиглэж байгаа, мөн хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт зэргээс шалтгаална. Хүүхдийн өсөлтийн муруйн шугам нь Z-онооны шугамтай дээш эсвэл доош чиглэлтэй огтлолцож болох ба хүүхдийн өсөлтийн өөрчлөлтөд маш нөлөөтэй юм. Хэрэв голч шугам руу хазайвал эерэг талын нааштай өөрчлөлт гэж үзэж болно. Хэрэв өсөлтийн муруй нь голч шугамаас доош хазайвал эрсдэл буюу асуудал учирч болзошгүйг заана. Хэрэв муруй нь (Z-онооны 0 шугам буюу ногоон шугам) голчийн ойролцоо, голчоос бага зэрэг дээш ба доош огтлолцож байвал хэвийн байна гэж ойлгоно.

Хэрэв хүүхдийн өсөлтийн муруй нь чиглэлээсээ эрс хазайх буюу Z-онооны шугамтай огтлолцохоор чиглэж байвал энэ өөрчлөлт нь асуудал үүсгэж болзошгүйг анхаарах хэрэгтэй юм. Жин буурах эсвэл нэмэгдэх чиг хандлагатай байвал хоол тэжээлийн асуудлаас сэргийлж эрт шийдвэрлэх нь ач холбогдолтой.

6.6 Өсөлтийн муруй огцом өгсөх ба буурах

Өсөлтийн муруй огцом хазайж өгсөх ба уруудах нь анхаарах шаардлагатайг харуулдаг. Өсөлтийн муруй огцом өгсөх нь хэрэв хүүхэд өмнө нь өвчтэй буюу хоол тэжээлийн байдал муу байсан бол хоол тэжээлийн байдал сайжирч өсөлтөө гүйцэж байгааг харуулдаг. Эсвэл өсөлтийн муруй дээшлэх нь жингийн илүүдэл болж болзошгүйг харуулдаг.

Харин жингийн үзүүлэлт жигд тэгш биш дээш доош болж ирвэл өндрийг үзэх шаардлагатай. Зөвхөн жин дангаараа нэмэгдэх нь асуудал юм. Хэрэв хүүхдийн жин ба өндөр нь харилцан хамааралтайгаар өсөж байвал өмнө байсан хоол тэжээлийн таагүй байдлаасаа (Халдварт өвчин) гарч өсөлтөө гүйцэж байгааг харуулна. Энэ тохиолдолд жин насны, өндөр насны хүснэгтүүд дээр огцом хазайлтууд харагдана. Харин жин өндрийн үзүүлэлтүүд тогтвортой байж болох юм.

Илүүдэл жинтэй, өсөлтийн муруйнд нь огцом хазайлтууд байхгүй хүүхдийн хувьд хэт их жин алдах нь муу зүйл юм. Жингийн илүүдэлтэй хүүхдийн өндөр нь нэмэгдэж байвал хүүхэд байх ёстой жин лүүгээ ойртох болно.

6.7 Өсөлтийн муруй тэгшрэх, зогсонгиших

Энэ нь хоол тэжээлийн асуудал байгааг харуулдаг. Хүүхдийн нас, өндөр нэмэгдээд жин тодорхой нэг түвшинд байгаад байвал асуудал тогтвортой байгааг харуулдаг. Хэрэв өндөр нэг түвшинд байгаад байвал энэ нь хүүхэд өсөхгүй байгааг заана. Жингийн илүүдэл ба таргалалттай хүүхэд тогтмол хугацаанд тогтмол жин

нэмж байвал хүүхэд жин өндрийн хэвийн үзүүлэлт рүү дөхөж байна гэсэн үг. Жингийн илүүдэлтэй хүүхэд жингээ гэж байвал зөв зүйл бөгөөд өндөртөө тохирох жин рүүгээ ойртох шаардлагатай. Гэвч хүүхдийн өндөр өсөхгүй бол асуудал байгааг харуулна. Энэ нь өндөр насны хүснэгтэнд өсөлтийн шугам илэрхий тэгширч байгаагаар илэрхийлэгдэнэ.

Хүүхдийн жин насны хүснэгт нь ЭХЭМД-т “ЭРЭГТЭЙ/ЭМЭГТЭЙ ХҮҮХДИЙН ЖИН НАСНЫ ХҮСНЭГТ (Төрснөөс хойш 24 сар хүртэл) ба (25-аас 60 сар хүртэл)” гарчигтайгаар байдаг. Эдгээр хүснэгтүүдэд Х тэнхлэг нь насыг, У тэнхлэг нь жинг кг-аар заана. Жин насны үзүүлэлтийг тэмдэглэхдээ:

Босоо шугамаар (Босоо шугамын завсраар биш) бүтэн сараар насыг цэглэн тэмдэглэнэ. Жишээ нь: Хэрэв хүүхдийн нас 5 нас 7 сартай бол (6 сар хүрээгүй гэсэн үг) цэгэн тэмдэглэгээ 5 сарын шугаман дээр л (5 ба 6 сарын шугамын завсраар биш) тэмдэглэнэ.

Жингийн хэмжилтийн хэмжээг хэвтээ шугамаар 0.1 кг-ын нарийвчлалтайгаар 7.8 кг гэх мэтээр цэглэн тэмдэглэнэ.

Хоёр ба түүнээс дээш хяналтад хамрагдалтын цэгэн тэмдэглэгээг хооронд нь зураасаар холбож өсөлтийн хандлагыг ажиглана.

Дараах хүснэгтэд 1-5 насны хүүхдийн толгой, цээжний тойргийг үзүүлэв.

Хүснэгт 3. 1-5 насны хүүхдийн толгой, цээжний тойрог

Эрэгтэй хүүхэд		Нас	Эмэгтэй хүүхэд	
Толгойн тойрог	Цээжний тойрог		Толгойн тойрог	Цээжний тойрог
45.4±1.4	44.7±1.9	1	44.5±1.5	42.9±2.0
47.3±1.3	47.0±1.5	2	46.3±1.1	45.8±1.6
48.6±1.5	48.6±1.7	3	47.3±1.0	47.2±1.4
49.2±1.4	49.8±1.9	4	48.3±1.4	48.3±1.8
50.0±1.5	51.3±2.4	5	49.1±1.4	50.3±2.1

АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Одоо байгаа шүдний тоо хэвийн: Хүүхдийн шүдний тоо тухайн насандаа тохирч байгаа буюу илүү байвал хэвийн (+), тохирохгүй буюу цөөн байвал хэвийн бус (-) гэж үзнэ.

Амны хөндийн асуудал байгаа эсэх: ЭХЭМД-ийн (ӨЭ-1 маягт) эмнэлгийн ажилтны бөглөх хэсэгт дурдсан шүдний зуулгаас бусад амны хөндийн эрүүл мэндтэй холбоотой асуудлыг (+) гэж тэмдэглэнэ. Сөрөг үзүүлэлт байхгүй бол (-) гэж тэмдэглэнэ.

Амны хөндийн асуудал гэдэгт амны хөндий өвчинтэй, шүд цоорсон эсвэл хэвийн бус шүдтэй, шүдний эмчилгээ шаардлагатай, шүдний ариун цэврийн байдал дунд ба муу үнэлгээтэй, буйл/завьж хэвийн бус үнэлгээтэй байдлыг багтаана.

Шүдний зуулт хэвийн эсэх: Шүдний хэвийн зуулт нь дээд төвийн үүдэн шүдний таслах ирмэгийн доод 1/3 нь доод үүдэн шүдний таслах ирмэгийг давж байрласан зуулт. Шаймий, орсгой, шулуун зуулт, муруй зуулт нь зуултын гажиг болно. Хэвийн биш зуулт хийж байвал (+) гэж тэмдэглэнэ.

Амны хөндийн эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн эсэх: Хүүхдэд үзлэг хийх үед эрүүл мэндийн ажилтан хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг үнэлэх ёстой ба хүүхэд ба түүний асран хамгаалагчид амны хөндийн эрүүл мэндийн асуудалтай эсэхийг харгалзахгүйгээр амны хөндийн эрүүл мэнд, эрүүл ахуй, шүд угаах аргачлал зэргийг заавал зөвлөнө. Зөвлөгөө өгсөн тохиолдолд (+) тэмдэглэгээ хийнэ.

7

НЭГ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ХЯНАЛТ

Хүүхдийг нэг нас хүртэл сар бүр үзэж идэвхтэй хяналтад хамруулна.

Хүснэгт 4. Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилт ба хооллолтын талаарх тэмдэглэл

1	2	3	4	5	6	7	8	9					
Тухайн нас сараар	Өсөлтийн үнэлгээнд хамрагдсан огноо	Хэмжилт (Тоог бичээд дараа нь өсөлтийн хүснэгтэд цэгээр тэмдэглэнэ.)	Амин дэм бичил бодисын хангалт			Хооллолтын байдал (Д,Т,Х,Н)	Хөгжлийн үнэлгээ (+, -)	Өвчлөл (А, С, А1, С1, Б)	Хүүхэд хамгаалал (+, -)	Үнэлгээнд ямар хэлбэрээр хамрагдсан			
											а	в	с
											Д аминдэм	А Аминдэм	Олон найрлагат бичил тэжээл
Жин /кг	Өндөр/ урт /см	Хаван	БЖИ										

Хүснэгтэд тэмдэглэгээ хийхдээ эцэг эх асран хамгаалагчийг аль болох оролцуулах нь чухал.

1. Хүүхдийн нас

Хоол тэжээлийн байдлын үнэлгээ хийлгүүлж буй хүүхдийн төрсөн он сар өдөр. Хэрэв сум, ӨЭМТ-д тусгай программ хангамж хэрэглэдэг бол уг программд хүүхдийн төрсөн он сар өдөр нь хүүхдийн дугаарын хамт автоматаар санагдсан байдаг.

2. Үзлэгт хамрагдсан хугацаа

Эрүүл мэндийн ажилтан хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, хоол тэжээлийн байдлыг хянахаар гэрээр нь очсон эсвэл хүүхэд эцэг эхийн хамт ЭМТ-д ирсэн он сар өдөр.

3. Хэмжилт

3.а Өсөлтийн хяналтад хамрагдаж буй хүүхдийн биеийн жингийн хэмжээг бичнэ. Жинг килограммаар бичнэ. Жишээ нь, хүүхдийн жин 6 кг 700 гр байвал 6.7кг гэж бичнэ.

3.в Өсөлтийн хяналтад хамрагдаж буй хүүхдийн биеийн урт эсвэл өндрийн хэмжээг бичнэ. Урт эсвэл өндрийн хэмжээг сантиметрээр бичнэ. Жишээ нь, хүүхдийн өндөр 1 метр 12 см байвал 112 см гэж бичнэ.

3.с Хүүхдийн хоёр хөлд хаван байгаа эсэхийг тодруулж бичнэ. Бүртгэлийн цонхонд хаван байгаа бол (+), байхгүй бол (-) гэж тэмдэглэнэ.

4. Амин дэм бичил бодисын хангалт

4.а А аминдэм уусан эсэх: Тухайн сард А аминдэм уусан 6-59 сартай хүүхдийн мэдээлэл (100000-200000 ОУН А аминдэмийг жил бүрийн 5 болон 11 дүгээр саруудад 6-59 сартай хүүхдүүдэд кампаничлан уулгадаг. Энэ нүдэнд А аминдэм уусан бол (+), уугаагүй бол (-) гэж тэмдэглэнэ.

4.в Д аминдэм уусан эсэх: Тухайн сард Д аминдэм уусан 0-36 сартай хүүхдийн мэдээлэл (50000 ОУН Д2 аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар сар бүр). Өндөр тунт Д2 аминдэм хүрэлцээгүй тохиолдолд Д3 аминдэмийг эмчийн зааврын дагуу дулаар уух ба энэ тохиолдлыг мөн Д аминдэмийг уусан хэмээн бүртгэнэ. Энэ нүдэнд Д аминдэм уусан бол (+), уугаагүй бол (-) гэж тэмдэглэнэ.

4.с Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл (ОНБТ) авсан эсэх: Бүртгэлийн цонхонд ОНБТ уусан бол (+), уугаагүй бол (-) тэмдэг бичнэ.

5. Хооллолтын байдал (Д, Т, Х, Н)

0-6 сартай хүүхдийн хувьд Д, Т, Х, Н үсгийн аль нэг тэмдэглэгдэнэ. Үүнд: Д - Эхийн сүүгээр дагнан хооллож (Эхийн хөхний сүүнээс өөр бусад шингэн, ус, цай, шүүс зэргийг огт авахгүй байхыг хэлнэ) байгаа, Т - Эхийн сүү орлуулагчаар дагнан хооллож байгаа, Х - Эхийн сүүний зэрэгцээ эхийн сүү орлуулагчаар хооллож байгаа буюу холимог хооллолт, Н - 6 сар хүрэхээс өмнө нэмэгдэл хоолонд орсон

6. Хөгжлийн үнэлгээ

ЭХЭМД-ийн хөх булантай хуудасны “МИНИЙ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ САРТАЙДАА” хэсэг дэх хүүхдийн хөгжлийн үзүүлэлтүүдийг тийм/үгүй гэсэн тэмдэглэгээг дугуйлж зурах талаар гэр бүлийн гишүүд эцэг эхэд зааж өгч ЭМТ-д үзүүлэхээр ирэхдээ тэмдэглэж ирэхийг анхааруулна. Асуумжийн дагуу бөглөж, (+) гэж тэмдэглэх ба бөглөөгүй бол (-) гэж тэмдэглэнэ. Тухайн насны хөгжлийн үзүүлэлтүүдийг хийж чадаж байгаа эсэхийг шалгаж, аль нэгийг нь эсвэл хэсэг бүлгийг нь хийж чадахгүй (Хөгжлийн хоцрогдолтой) хүүхдийг ЭХЭМД-т тэмдэглэж дараагийн сар хүртэл хянана. Хүүхдийн хөгжлийн энэхүү үзүүлэлтүүд нь ЭХЭМД-ийн

маш чухал хэсэг бөгөөд хүүхдийн танин мэдэхүй, оюуны хөгжлийг зөв үнэлж дүгнэснээр хүүхдийг хөгжлийн хоцрогдлыг эрт таньж хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх чухал хэрэгсэл болох юм.

7.Өвчлөлийн байдал

Тухайн сард ямар нэг өвчнөөр өвчилсөн бол А, А1, С, С1, Б үсгийн аль нэгийг тэмдэглэгдэнэ.

А Тухайн сард амьсгалын цочмог халдвараар өвчилсөн (Тухайн сард хүүхэд хэдэн удаа өвчилснийг тооцохгүй).

А1 Тухайн сард амьсгалын цочмог халдвараар өвчилж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан хүүхэд (Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэдэгт өвчний улмаас эмнэлэг, эмчид хандах, эм бичүүлж эмийн сангаас авч хэрэглэснийг хэлнэ. Тухайн сард хүүхэд хэдэн удаа өвчилснийг тооцохгүй).

С Тухайн сард суулгалтаар өвчилсөн (тухайн сард хүүхэд хэдэн удаа өвдсөнийг тооцохгүй).

С1 Тухайн сард суулгалтаар өвчилж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан хүүхэд (Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэдэгт суулгалтын улмаас эмнэлэг, эмчид хандах, эм бичүүлж эмийн сангаас авч хэрэглэснийг хэлнэ (Тухайн сард хүүхэд хэдэн удаа өвдсөнийг тооцохгүй).

Б Тухайн сард хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, бойжилтод нөлөөлөхүйц өвчнөөр өвчилсөн бол Б гэж тэмдэглэнэ (цочмог халдварт өвчин орно).

8.Хүүхэд хамгаалал

Хүүхдийг үзэх, жинлэх явцад хувцсыг нь тайлахдаа хүүхдийн биед илэрч буй ямар нэг гэмтлийн шинж байвал гэмтлийн зэргийг харгалзахгүйгээр (+) гэж тэмдэглэнэ. Гэмтэлгүй бол (-) гэж тэмдэглэнэ.

ЭХЭМД дэх эцэг, эхэд зориулсан асаргаа сувилгааны талаар эцэг эхийн ойлголтыг заавал асууж шалгаж ойлгоогүй зүйлийг хэлж өгнө.

Эцэг эх асран хамгаалагчдаас хүүхдээ өсгөж бойжуулахад ямар бэрхшээл байгаа болон хүүхдийнхээ талаар сэтгэл зовнисон аливаа асуудал байгаа эсэхийг асууж зөвлөлдөх нь маш чухал.

Гэр бүлийн гишүүд **ЭХЭМД**-ийг тогтмол ашиглаж хүүхдийнхээ өсөлт хөгжил, эрүүл мэндийг хянаж байх нь хүүхдийн эсэн мэнд өсөж бойжих үндэс юм.

Дээрх хүснэгтийг бөглөхдөө хүүхдийнхээ дэргэд байж тэмдэглэх ба жин урт өндрийг тэмдэглэхийн өмнө **ЭХЭМД**-ийн арын хуудас дахь өсөлтийн хүснэгтэд цэглэн тэмдэглэнэ.

Хүүхдийг нэг нас хүрэхэд өрхийн эмч ЭХЭМД-т нь 2 хувь дүгнэлт бичиж, нэг хувийг ЭМТ дээрээ хадгална.

Нэг наснаас хойш ЭХЭМД-т бичсэн насны товллын дагуу үзэж тэмдэглэх ба хүүхдийг 18 сартай, 36 сартайд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулна. Энэ үзлэгийг өрх, сумын ЭМТ нэгдсэн журмаар зохион байгуулах нь зохистой.

Тухайлбал, 2019 оны 6 дугаар сард 18 сар хүрэх хүүхдүүд нь 2017 оны 12 дугаар сард төрсөн байх ба 18 сараас 18 сар 29 хоногтой бүх хүүхдийг эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулна гэсэн үг юм. Энэхүү үзлэгийг хөгжлийн үнэлгээтэй нэгтгэн хийж байгаагаараа цогц үзлэг гэсэн ойлголт болж байгаа юм. Цогц үзлэгийн үед ашиглах үзлэгийн маягтад хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, хөгжлийн гол үзүүлэлтүүдийг асуултуудын дагуу бөглөж бичнэ. Ингэхдээ хүүхдийн эрүүл мэнд хөгжлийн төлөө эмч, эрүүл мэндийн ажилтан, эцэг эх нэгэн зорилготой гэдгийг ойлгуулна. ЭХЭМД-ийн эцэг эхэд зориулсан хөх хуудас дахь “Хүүхдээ өсгөж бойжуулахад санаа зовнисон асуудал байна уу? Зан төрхийн талаас болон аливаа зүйлийг сурахад?” гэж асууж хариултыг анхааралтай сонсох нь чухал. Хүүхдийн зан төрхийн талаар эцэг эхээс асууснаар хөгжлийн тухай чухал мэдээлэл олж мэдэх боломжтой. Учир нь, эцэг эхчүүд хүүхдийнхээ зан төрхийг хүүхдийн хөгжлийн үзүүлэлттэй холбон үзэхгүй байх нь ажиглагддаг. Гэтэл хөгжлийн хоцрогдол нь зан төрхөөр илэрхийлэгддэг. Эцэг эхийн туршлага, хүүхдэд анзаарагдсан аливаа илрэлүүдийн талаарх ажиглалт хамгаас үнэтэй мэдээлэл болдог. Хүүхэд эмнэлгийн байгууллагад өвчний учир, дархлаажуулалт болон бусад шалтгаанаар хандах бүх тохиолдолд энэ асуудлыг анхаарах хэрэгтэй. Цогц үзлэгийн маягтыг өрх сумын ЭМТ дээр хадгалах ба үзлэг хийсэн тэмдэглэлийг ЭХЭМД-т бичиж тэмдэглэнэ. Үзлэгийн дүнг үндэслэн цаашид эмчилгээ, шинжилгээ, нэмэлт үнэлгээ шаардлагатай хүүхдийг холбогдох эрүүл мэндийн байгууллага болон мэргэжилтэнд илгээнэ.

Гэрийн эргэлт

Нэгхүртэлх насны бүх хүүхдийг идэвхтэй хяналтанд хамруулахдаа хүүхдийг тодорхой саруудад нь өрх сумын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч гэрээр эргэхдээ, ЭХЭМД дэх асран хамгаалагчийн бөглөсөн “Гэрийн эргэлтийн өмнөх асуумж”-ийг шалгаж, “Эргэлтийн хуудас”-т тэмдэглэн холбогдох зөвлөгөөг өгнө.¹

¹ ЭХЭМД-т шинээр орсон. (Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/546 тоот тушаалаас тодруулж үзнэ үү.)

Гэрийн эргэлттэй холбоотой шаардлагатай мэдээлэл

- Гэрийн эргэлтийг нэг хүртэлх сартайд сард 4 удаа, 1-2 сартайд сард 2 удаа, 3-6 сартай хүүхдийг сард 1 удаа, 7-12 сартайд улиралд нэг удаа эргэнэ.
- Эмнэлгийн мэргэжилтэн нь гэрийн эргэлтээр очихоос өмнө хүүхдийн эцэг эх, асрамжлан хамгаалагч нь ЭХЭМД дэх “Гэрийн эргэлтийн өмнөх асуумж”-ийг урьдчилан бөглөх талаар гэр бүлийн гишүүдэд тайлбарлаж өгнө.
- Эмнэлгийн мэргэжилтэн нь гэрээр эргэхдээ ЭХЭМД дэх “Гэрийн эргэлтийн үнэлгээ” гэсэн хүснэгт бүхий хуудсыг ашиглан хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, гэр бүлийн дэмжлэг, аюулгүй байдал, хооллолт, асаргаа сувилгааны талаар үнэлж, зөвлөгөө өгнө.
- Гэрээр эргэх тоолонд ЭХЭМД-т тэмдэглэн, асран хамгаалагчаар гарын үсэг зуруулна. Хүүхэд өвчилсөн тохиолдолд ӨЭ 4А, 4Б маягт (ХӨЦМ)-ын дагуу үнэлж, ангилан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд илгээнэ.

Эхний эргэлтийг эмч, сувилагч заавал хамтарч хийнэ.






ЭХЭМД дэх гэрийн эргэлтийн зөвлөмжийн дагуу хүүхдийн насанд тохирсон зөвлөгөөг өгнө.

8

ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ШАЛГАХ

Өрх сумын эмч, ээлжит үзлэгийн үед хугацаандаа дархлаажуулалтад хамрагдсан эсэхийг шалгаж ЭХЭМД-т тэмдэглэх ба хамрагдаагүй бол хэрхэн дархлаажуулалтад орохыг зөвлөх болон дархлаажуулалтын ач холбогдлыг эцэг эхэд тайлбарлаж өгнө.

Хүснэгт 5. Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлол (2019)

Товлол Вакцины нэр	Төрөнөөс хойш 24 цагийн дотор	2 сартайд	3 сартайд	4 сартайд	5 сартайд	9 сартайд	1 нас 2 (24 сар) сартайд	2 настайд	7 настайд	15 настайд
	БЦЖ (Сүрьеэгийн эсрэг вакцин) (BCG)	0 тун								
В Гепатитийн эсрэг вакцин (Нер В)	0 тун									
Халдварт саагийн эсрэг вакцин (Polio)	 0 тун	 I тун	 II тун	 III тун	 IV тун					
Тавт вакцин (Сахуу, хөхүүл ханиад, татран, +В Гепатит, хемофиллюс инфлюэнза В) (Penta)		I тун	II тун	III тун						
Пневмококкийн эсрэг вакцин (PCV)		I тун		II тун		III тун				
УГУ вакцин (Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг) (MMR)						I тун		II тун		
А Гепатитийн эсрэг вакцин (Нер А)							I тун	II тун		
Сахуу, татрангийн вакцин (DT)									I тун	II тун

Бусад вакцинууд (Гепатит А-гийн эсрэг, ПЭВ 13 (пневмококкийн эсрэг вакцин), томуугийн эсрэг гэх мэт):

- _____ Огноо ___/___/___
- _____ Огноо ___/___/___
- _____ Огноо ___/___/___
- _____ Огноо ___/___/___
- _____ Огноо ___/___/___
- _____ Огноо ___/___/___

Эрүүл мэндийн ажилтан дараах байдлаар дархлаажуулалт хийсэн талаар тэмдэглэнэ.

Хүснэгт 6. Дархлаажуулалтад хамрагдсан талаарх тэмдэглэл

Товлол	Вакцинууд	Эцэг эхийн зөвшөөрөл	Хүүхдийн биеийн байдлыг үнэлэх	Эмчийн зөвшөөрөл	Хийсэн огноо/сери
Төрснөөс хойш 24 цагийн дотор	БЦЖ (Сүрьеэгийн эсрэг вакцин) (BCG)	Тийм/Үгүй			
	Халдварт саагийн эсрэг вакцин (Polio)	Тийм/Үгүй			
	В Гепатитийн эсрэг вакцин (Нер В)	Тийм/Үгүй			
2-4 саргайд	Халдварт саагийн эсрэг вакцин (Polio)	Тийм/Үгүй			
	Тавт вакцин (Сахуу, хөхүүл ханиад, татран, +В Гепатит, хемофилус инфлюэнза В) (Penta)	Тийм/Үгүй			
	Пневмококкийн эсрэг вакцин (PCV)	Тийм/Үгүй			
5 саргайд	Халдварт саагийн эсрэг вакцин (Polio)	Тийм/Үгүй			
9 саргайд	УГУ вакцин (Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг) (MMR)	Тийм/Үгүй			
	Пневмококкийн эсрэг вакцин (PCV)	Тийм/Үгүй			
1 нас 2 (24 сар) саргайд	А Гепатитийн эсрэг вакцин (Нер А)	Тийм/Үгүй			
2 настайд	УГУ вакцин (Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг) (MMR)	Тийм/Үгүй			
	А Гепатитийн эсрэг вакцин (Нер А)	Тийм/Үгүй			
7 настайд	Сахуу, татрангийн вакцин (DT)	Тийм/Үгүй			
15 настайд		Тийм/Үгүй			

9

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүүхдийн хөгжлийн онцлогийг мэдэх нь тухайн хүүхдийн хөгжил насандаа тохирч байгаа эсэхийг тогтооход чухал ач холбогдолтой. Эмнэлгийн мэргэжилтнүүд, эрүүл мэндийн ажилтан, эцэг эхчүүд, цэцэрлэгийн багш нар дараах үзүүлэлтийг мэдэж хүүхдийн хөгжлийг дэмжих чадварыг эзэмшинэ. Хүүхдийн төрсний эхний саруудад оюуны хоцрогдол нь биеийн хөгжлийн хоцрогдлоор илэрдэг тул хөдөлгөөн идэвх муутай, жин нэмэгдэхгүй хүүхдийг онцгой хянах хэрэгтэй.


Хүүхдийн хөгжлийг тандаж хянаж, хөгжлийн хоцрогдлын эрсдэлтэй хүүхдийг олж илрүүлэх үйл явц нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага буюу өрх, сумын ЭМТ-ийн үйл ажиллагаатай шууд холбогдох ёстой.


Хүүхдийг өсөлтийн хяналт болон дархлаажуулалт, эсвэл үзүүлэхээр ирэхэд хүүхдийн өсөлт хөгжлийн хэсгийг тэмдэглэсэн эсэхийг шалгаад, тэмдэглээгүй бол ээжтэй нь хамтдаа тэмдэглэж цаашид хэрхэн энэ хуудсыг ашиглах талаар зааж сургах хэрэгтэй. Мөн танд үзүүлэх, зөвлөгөө авахаар ирж буй хүүхдийг доорх хүснэгтэд заасны дагуу хөгжлийг үнэлж гэр бүл эцэг эхэд зөвлөгөө өгөөрэй.


Энэ хүснэгтэд хүүхдийн хөгжлийн үе шатны үзүүлэлтүүдийг нас насаар багцлан ЭХЭМД-ийн хөх хуудсанд байгаа асуултуудаас илүү дэлгэрэнгүйгээр эмч, мэргэжилтнүүд хүүхдийн хөгжлийг хэрхэн үнэлж, эцэг эх, гэр бүлд зөвлөх талаар тодорхой тусгасан болно.


ЭХЭМД дэх “МИНИЙ ХҮҮХДИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛ ... САРТАЙДАА” гэсэн хөх булантай хуудсууд дахь хүүхдийн хөгжлийн үзүүлэлтүүдийг тэмдэглэж хүүхдийнхээ хөгжлийг тогтмол хянахын чухлыг гэр бүлд ойлгуулах нь эрүүл мэндийн ажилтнууд, эмнэлгийн мэргэжилтний үүрэг мөн.


Хүснэгт 7. Хүүхдийн хөгжлийн үзүүлэлтүүдийг шалгах, үнэлэх, зөвлөгөө өгөх арга


Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p>Нярай төрснөөс 1 сар 29 хоногтой</p> 	1. Суниах	Өлгийг задлахад хүүхэд гар хөлөө хөдөлгөн 1 хоромд нилээд хэдэн удаа суниаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд өөрөө гар хөлөө хөдөлгөх тул унахааргүй газар байрлуулна. • Хүүхдээ тэврээд өөдөөс нь харан дуудах, • 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох нь хүүхдэд нэн чухал бөгөөд хөхүүлж байх үедээ хүүхэдтэйгээ олон дахин ярьж, инээмсэглэж, нүдээрээ харьц. • Хүүхэдтэйгээ удаан ярилц, эсвэл түүнийг авч байх үедээ бүүвэйн дуу дуул. • Хүүхдийн алганд хуруугаараа хүрэлц. Байнга бээлий өмсгөхөөс зайлсхий.
	2. Гар хөлөө хөдөлгөх	Хүүхэд өөрөө гар хөлөө хөдөлгөж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	3. Царай руу харж харьцах	Хүүхдээ тэврээд өөдөөс нь харан дуудах, өхөөрдөхөд нүүр рүү тань харж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	4. Чанга дуу, чимээг мэдрэх	Чанга дуу, чимээг гарсан зүгрүү харж мэдэрч хариу үйлдэл үзүүлж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	5. Гарт бариулсан бүхнийг атгана	Долоовор хуруугаа гарт нь атгуулахад чанга атгаж байвал ТИЙМ гэнэ	


Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p style="text-align: center;">2-3 сар</p> 	<i>Хэл яриа-Харилцаа, Нийгэмшихүй</i>		• Дээрхийн адил
	1. Инээмсэглэх	Унтаж байхдаа үнэгчлэн инээж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	2. Эх нь тэврэхэд баярлах	Хүүхдээ тэврээд өөдөөс нь харж дуудах, өхөөрдөхөд инээмсэглэдэг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	<i>Мэдрэхүй (Сонсгол)</i>		
	3. Чанга дуу, чимээг мэдрэх	Хүүхдийн чих болон ард нь дуугардаг тоглоом хөдөлгөж чимээ гаргах үед хүүхэд хөдөлгөөнгүй болох эсвэл царай нь хувирч байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	<i>Мэдрэхүй (Хараа)</i>		
	4. Хөдөлж байгаа зүйлийг дагуулж харах	Эх нь хүүхдэдээ зөөлөн хүрч, толгойгоо удаан хөдөлгөхөд хүүхэд ээжийнхээ нүүрийг дагуулан хардаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	<i>Хөдөлгөөн</i>		
5. Түрүүлгэ нь харуулан хэвтүүлэхэд толгойгоо өндийлгөх	Хүүхдийг сэрүүн байх үед нь түрүүлгэ нь харуулж хэвтүүлээд түүнд хандаж ярих буюу толгой дээр нь тоглоом шажигнуулан дуугаргахад толгойгоо өргөж түүнийг харж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		


Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p>3-4 сар</p> 	<i>Хэл яриа-Харилцаа, Нийгэмнэхүй</i>		<ul style="list-style-type: none"> • Ямар ч үед хүүхдийнхээ нэрээр дуудаж мэндэлж байгаарай. • Хүүхэдтэйгээ үргэлж ярьж, инээж, тоглож биед нь зөөлөн хүрч бай. • Хүүхдээ гунганаж дуугарах үед нь түүнийг дэмжиж ярь. • Хүүхдийн дээр өлгөсөн тоглоомыг сэгсэрч анхаарлыг нь татан тоглоомыг савлуулахад түүнийг дагуулан харна. Дараа нь хүүхэд түүнд хүрэх гэж сарвайна. Энэ үед нь тоглоомонд хүрэхэд нь тусал.
	1. Ганганах	Хүүхдийнхээ нэрээр дуудах буюу ярихад хариуд нь гунганаж авиа гаргаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	2. Ярихад ход ход инээх	Хүүхдэд хандаж өхөөрдөхөд өөдөөс чанга инээж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	<i>Хөдөлгөөн</i>		
	3. Гараас атгаж өндийх	Хүүхдийн гарт гараа бариулахад таны хурууг атгаж өндийж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	4. Толгойгоо өргөх	Хүүхдийг түрүүлгэ нь харуулан хэвтүүлэхэд хоёр гар дээрээ тулаад толгойгоо 90 хэм өргөж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
<i>Мэдрэхүй (Хараа)</i>			
5. Тод өнгийн зүйлийг дагуулж харах ба барьж авах гэж оролдох	Хүүхдийн дээр өлгөсөн тоглоомыг сэгсэрч анхаарлыг нь татан тоглоомыг савлуулахад түүнийг дагуулан хараад, дараа нь хүүхэд түүнд хүрэх гэж сарвайж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		


Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p>5-6 сар</p> 	<i>Нийгэмшихүй</i>		<ul style="list-style-type: none"> • Энэ үед хүүхэдтэйгээ аль болох харилцаж энхрийлж ярилцаж байгаарай • Хүүхэд энэ үед дуу чимээг хооронд нь ялгаж чаддаг. Түүнтэй өөрийн хийж байгаа зүйл болон сонирхдог зүйлсийх нь талаар ярилц. • Энэ үеэс хүүхэд мөлхөж эхлэх ба аюулгүй орчин бүрдүүлж, сонирхдог тоглоомыг нь зайтай тавин дэмжлэг үзүүл.
	1. Өөрт нь хандахад баярлаж сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх	Эцэг, эхээ хараад баярладаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	<i>Харилцаа, Мэдрэхүй (Сонсгол)</i>		
	2. Нэрээр нь дуудахад эргэж харах	Харагдахгүй байрлалаас нэрээр нь дуудахад эргэж хардаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	<i>Хөдөлгөөн</i>		
3. Мөлхөх гэж оролдох	Тоглоомыг нь зайтай тавих буюу ээж нь зайнаас дуудахад мөлхөхийг оролдож байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
4. Өнхрөх	Хүүхдийг дээш нь харуулж хэвтүүлэхэд түрүүлгээ, түрүүлгэ нь харуулахад дээш харж өнхөрч чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p>7-8 сар</p> 	Танин мэдэхүй		<ul style="list-style-type: none"> Хүүхдээ тэврэхийг хүсч байгаагаа хэл, яриа болон биеийн хөдөлгөөнөөрөө үргэлж илэрхийлж бай. Хүүхэд таны хийж байгаа зүйлийг сонирхох үед нь энэ тухай ярилц. Хамтдаа ном уншиж зургийг нь тайлбарлаж өг. Таны хүүхдээ тэврэх цаг багасна. Өөрийнх нь барьж чадахаар тоглоомуудаар тоглуул. Тоглож байх үед нь анхаарлаа бүү салга. Хүүхдийг суухад нь тусалж дэмжиж өг.
	1. Танихгүй хүнээс бишүүрхэх	Хүүхэд танихгүй хүнтэй уулзахад бишүүрхэх ба та түүнтэй элэгсэг дотно харилцахад хэсэг хугацааны дараа бишүүрхэхээ болин дасдаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	Нийгэмшихүй		
	2. Авахуулахыг хүссэн үедээ гараа өргөн тэмүүлэх	Авахуулахыг хүссэн үедээ гараа өргөн өөдөөс тань тэмүүлдэг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	Хэл яриа-Харилцаа		
	3. Шулганах (Нэг үетэй богино үг хэлэх)	Ба, ба, ма, ма, да, да гэх мэтийн үе давтан шулганадаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	Мэдрэхүй (Сонсгол)		
	4. Дуу гарсан зүг рүү эргэж харах	Дуу чимээ гарсан зүг рүү эргэж харж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	Мэдрэхүй (Хараа)		
5. Өндрөөс унах зүйлийг дагуулж харах	Хүүхдээ сууж байхад өмнө нь тоглоом барьж доошлуулахад түүнийг дагуулан харж барьж авахыг оролдож байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
Хөдөлгөөн			
6. Юмыг хоёр гартаа шилжүүлэн барих	Нэг гарт нь юм бариулахад нөгөө гартаа шилжүүлэн барьж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
7. Ганцаараа суух	Дэмжлэггүйгээр ганцаараа сууж чаддаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.		

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө	
<p style="text-align: center;">9-10 сар</p> 	<i>Танин мэдэхүй</i>		<ul style="list-style-type: none"> • Хүүхэдтэйгээ алгаа ташиж, дохио зангаа ашиглаж, нуугдаж тогло. • Хүүхэддээ чанасан хулуу, агшаасан будаа зэрэг зөөлөн хоолыг жижиглэн аманд нь хийж өгвөл тэр өөрөө идэж чадна. Харин хахахаар самар болон хатуу зүйлийг өгч болохгүй. • Нүүр царайны болон биеийн дохио зангаа зааж өг. • Хүүхэдтэйгээ намуухан, зөөлөн дуугаар ярилц. • Мөлхөх, зогсоход нь аюулгүй газар бэлд. Суусан газраасаа босоход нь тусал. Ингэхдээ хүүхдээ босгохын тулд сандал дээр анхаарлыг нь татах зүйл тавьж, тэрийг авах гэж оролдох үед сандлыг нь барьж байх хэрэгтэй. 	
	1. Нуугдаж тоглоно	Хөшигний араар эсвэл юмны араар нуугдаж тоглодог бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	<i>Бие дааж хийх үйлдэл-Эрүүл мэнд</i>			
	2. Идэх юмыг өөрөө барьж идэж чадна	Идэх юм бариулахад өөрөө бариад ам руугаа хийдэг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	<i>Хэл яриа-Харилцаа</i>			
	3. Өөрийн хүссэн зүйлээ заах эсвэл дохио зангаа хэрэглэх	Авах гэсэн зүйлээ заах мэтээр дохио зангаа хэрэглэдэг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	4. Яриа болон царайны илрэлийг ойлгох, хариулах	Өөрийг нь зандарсан, магтсан ярианы илрэл, дууны өнгө аясыг ойлгодог бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	5. Цөөн үг хэлнэ	Аав, ээж, май, өг гэх мэт цөөн үг хэлдэг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	<i>Хөдөлгөөн</i>			
6. Хуруугаараа юмыг чимхэж болон атгаж авах	Жижиг зүйлийг хуруугаараа чимхэх болон атгаж авч чаддаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.			
7. Мөлхөх ба юмнаас татаж босох	Чөлөөтэй газар тавихад мөлхөх ба ойролцоох зүйлээс татаж босож чаддаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.			

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө	
<p>11-12 сар</p> 	Хэл яриа-Харилцаа			
	1. Даган дуурайх	Гараа даллах, алгаа таших, гэх мэт үйлдлийг дуурайж хийж чаддаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.	<ul style="list-style-type: none"> • Эцэг эхчүүд өөрсдөө үлгэр дуурайлал үзүүл. Жишээ нь: хүндэтгэх, баяртай байхад хацрыг нь үнсэх. Эцэг, эхчүүд ямар ч үед тэр үүнийг хийж чадвал түүнийг сайшааж байх хэрэгтэй. • Жижиг хуванцар аягатай усыг өөрөө барьж уухад нь тусал. 	
	2. Богино үгийг зөв хэлнэ.	Май, өг г.м. богино үгийг зөв хэлж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	Бие дааж хийх үйлдэл-Эрүүл мэнд			<ul style="list-style-type: none"> • Эргэн тойрных нь хүмүүсийн тухай богино үгээр, үнэн зөв хэлж зааж өг. Жишээ нь: аав, ээж, эмээ г.м. • Ямар ч үед таны хүүхэд хийж болохгүй зүйлийг хийхийг хүсвэл болохгүй гэж хэлэх хэрэгтэй. • Хоёр гартаа юмыг нэг, нэгээр нь барих хооронд нийлүүлэхэд нь тусал. Эхлээд түүнд яаж хийхийг нь үзүүл. • Хүүхдээ газар тоглож байгаад босохдоо халтирч унахааргүй аюулгүй газар байлгаж, байнга анхаарлаа хандуулж бай.
	3. Аяганаас ууж чадна	Аягаа өөрөө барьж уух гэж булаацалдах ба бариад ууж чаддаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	Хөдөлгөөн			
4. Хоёр гартаа юмыг нэг, нэгээр нь бариад хооронд нь мөргөлдүүлж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	Хоёр гарт нь хоёр юм бариулахад нэг, нэгээр нь бариад хооронд нь мөргөлдүүлж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.			
5. Ганцаараа зогсох	Дэмжлэггүйгээр ганцаараа тэнцвэрээ олоод зогсож чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.			

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө	
<p>13-15 сар</p> 	<i>Нийгэмшихүй, Танин мэдэхүй-Үйлдэх</i>			
	1. Амархан үйлдлийг дуурайх	Үсээ самнах г.м хялбархан үйлдлийг дуурайж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	<ul style="list-style-type: none"> • Хялбархан үйлдлийг дуурайж хийх боломж хүүхэддээ олго. Жишээ нь: Үсээ самнах г.м. Хийж чадсан үед нь сайшааж магт. • Халбагаа бариад ам руугаа хоолоо хийх боломж олго. Халбага нь хурц үзүүртэй биш, жижиг байх хэрэгтэй. • Хүүхдэд биеийн хэсгүүд, эрхтнүүд, гэр доторх эд юмсын нэрийг зааж өг. Юм хийж байхдаа дуу дуулж өгч бай. • Өөр өөр хэлбэр дүрстэй, гадаргуутай зүйлсийг хүүхэддээ үзүүл. Тоглосныхоо дараа тоглоомоо хайрцагт нь хийж хурааж сурга. Тоглож байх үед нь анхаарлаа хандуул. • Хүүхдээ явахад аюулгүй, чөлөөтэй газар байлга. Хүүхэд хөлд орсон үедээ заримдаа ярихаа больдог тал бий. 	
	<i>Бие дааж хийх үйлдэл-Эрүүл мэнд</i>			
	2. Халбага бариад ам руугаа хоолоо хийх	Халбага бариулахад ам руугаа хоолоо хийхийг оролдож байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	<i>Танин мэдэхүй-Үйлдэх</i>			
	3. Энгийн зааврыг гүйцэтгэх, хариу үйлдэл үзүүлэх. Жишээ нь: Биеийн хэсгүүд болон зургийг заах, 1-3 үгээр ярих	Хүүхдээс биеийн хэсгүүд, эрхтнүүд, гэр доторх эд юмсын нэрийг асуухад заадаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	<i>Хөдөлгөөн</i>			
4. 2-3 ширхэг зүйл эсвэл шоог авах	2-3 ширхэг зүйл эсвэл шоог нэг гартаа барьж чаддаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.			
5. Хөлд орох (Ганцаараа явж чаддаг болох)	Юм түшихгүйгээр ганцаараа явж чадаж бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.			

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p>16-18 сар</p> 	Нийгэмшихүй		<ul style="list-style-type: none"> • Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ тоглох цаг гаргах хэрэгтэй. • Дохио зангаа зааж өг. Жишээ нь: Толгойгоо сөгерэх нь үгүй гэсэн үг г.м. • Аяганаас бага багаар ус уухад нь тусал. • Хүүхдэдээ команд өгч бай. Жишээ нь: Тоглоомоо хайрцагтаа хий. Хэрвээ ойлгохгүй байвал эхлээд өөрөө хийж үзүүлж ярилц. • Хүүхдэдээ тоглоомоо хийх хайрцаг, зураг зурах будгийн харандаа, байшин барих эвлүүлдэг тоглоом зэргийг бэлтгэж өгөөд түүнтэй хамтдаа тоглож бай. • Хүүхдэдээ явж хөдлөх, авирах, чөлөөтэй гүйх зайтай газар сонго. Шагаар өгсөхөд нь хөтөлж гарнаас нь барьж тусал.
	1. Сонирхсон зүйлдээ баярлах, дургүй бол үгүй гэхийг мэднэ.	Дургүй байгаа бол толгойгоо сөгерэх, үгүй гэж хэлэх мэтээр дохио зангааг мэдэж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	Бие дааж хийх үйлдэл-Эрүүл мэнд		
	2. Аягатай ус, сүү зэргийг бариад уух	Аягатай цай, ус, сүү зэргийг бариад ууж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	Хэл яриа-Харилцаа		
	3. Зарим хялбар зүйлийг эцэг эхийн заавраар хийж чадна. 5 орчим үгийн утгыг хэлж чадна.	Зарим хялбар зүйлийг эцэг, эхийн заавраар хийж чаддаг. 5 орчим үгийн утгыг хэлж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	Танин мэдэхүй-Үйлдэх		
4. 2-3 шоог давхарлан өрж чадна, нуусан юмыг олж чадна.	2-3 шоог дээр дээрээс нь давхарлан өрж чаддаг, нуусан юмыг олж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
Хөдөлгөөн			
5. Гүйж чаддаг болно.	Чөлөөтэй гүйж чаддаг бол ТИЙМ гэж тэмдэглэнэ.		


Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p style="text-align: center;">19-24 сар</p> 	<p><i>Хэл яриа-Харилцаа, Нийгэмшихүй</i></p>		<ul style="list-style-type: none"> • Баярласан талархсанаа илэрхийлж алга таших, баярлаж инээн баясах хөдөлгөөнийг давтан зааж өгөх • Эцэг эхчүүд энэ буруу зүйл гэдгийг ойлгуулж ахиж тэгж болохгүй гэдгийг ахин дахин хэлж үйлдлээр ойлгуулна. • Өөрийнхөө тоглоомыг хайрцгандаа хийхийг хэлж зааж сургах • Ах эгчийнхээ эд зүйлсийг хамаагүй оролдож булаацалдаж болохгүй өгөөрэй гэх мэт ярьж үйлдлээр харуулна. • Тоглоомоо эзэнд нь өгөөрэй сайн хүүхэд өгдөг гэж урам оруулсан үг хэлж зааж өгөх • Найз нөхөдтэйгөө тоглоомоо харамлахгүй тоглуулж, бусдын эд, тоглоомыг булаахгүй эвтэй тоглохыг байнга зөвлөж бишүүрхэхгүй байхыг дэмжинэ.
	<p>1. Баярлах дургүйцэх, айх, уурлах зэрэг сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлж чадна. Үүнд: Ууртай байгаагаа нүүрээ алгаараа дарах, хөдлөхгүй доош харж зогсох, дургүй байгаагаа биеэ займчиж илэрхийлэх, орилох гэх мэт</p>	<p>Баярлах үедээ чанга инээж, нүүр царайнаас нь мэдэгдэж байвал Тийм гэж үнэлнэ.</p>	
	<p>2. Хүүхэд болохгүй гэж хорисон зүйлийг хийсэн үедээ хэн үүнийг хийв гэхэд дуугаа хурааж доошоо харах, бусадруу зааж булзааруулах, гэмшиж уйлах</p>	<p>Буруу үйлдэл хийснээ ойлгож царайгаа төв болгож байвал, буруу хийсэндээ айж уйлж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.</p>	
	<p>3. Өөрийн тоглоом, хувцас зэргийг харж таниад баярлаж хөөрнө.</p>	<p>Өөрийн нь хувцас, тоглоом, бусад зүйлийг нь асуухад минийх гэж авч байвал ТИЙМ гэж үнэлнэ.</p>	
<p>4. Үеийнхэнтэйгээ тоглоно</p>	<p>Хүүхдүүдтэй эвсэг тоглож чөлөөтэй хөдөлж тоглож байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.</p>		


Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<i>Нийгэмшихүй</i>			<ul style="list-style-type: none"> • Хүүхдэдээ зурагтай ном уншиж өгөх, хийж буй үйлдлийг нь өөрийн биеэр дуурайж хөдөлж үзүүлэх, зурган дээрхи үйлдлүүдийг хүүхдэдээ ойлгомжтойгоор хийж үзүүлж өөрийг нь дагуулж хийлгэж сургах. • Хүүхдийг хөтөвчинд суулгаж сургах, баах шээх үеэ бусдад ойлгуулдаг болгох талаар сургах, гар угаах үйлдлийг дуурайлган хийлгэж сайн хийж байгааг нь байнга урамшуулж байх. Гарыг нь угаах болсон байна муухай болсон байгааг нь ойлгуулах зааж харуулах угаасны дараа гоё болсон байгааг харуулж магтах
	5. Хүүхэлдэйн кино болон зурагтай номыг өөрийн сонирхдог хүүхэлдэйн кино, эсвэл зурагтай номыг үзэж, хөгжилтэй хэсгийг нь харж баясах.	Зурагт ном үзээд хийж байгаа үйлдлийг дуурайх, хүүхэлдэйн баатруудыг хийдэг үйлдлийг дуурайж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
<i>Бие дааж хийх үйлдэл-Эруул мэнд</i>			
	6. Өмдөө тайлж хөтөвчөө эрэх	Бие засах гэж хөтөвчиндөө суух, Хөтөвчиндөө шээх баах гэснээ асран хамгаалагчдаа ямар нэг байдлаар илэрхийлж ойлгуулж байвал ТИЙМ гэнэ.	
	7. Гараа угаах гэж усаар тоглох, шүдний сойз авч ам руугаа хийж шүдээ угаах дүр үзүүлэх	Бусдыг дууриан гараа угаахыг оролдох хоолны өмнө гараа угаах шүдээ цэвэрлэх зэрэг өдөр тутмын үйлдлийг хийж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	8. Малгайгаа аваад толгой дээрээ тавих, өмдөө өмсөх өрөөсөн хөлдөө углах	Хувцсаа өмсөх гэж оролдох, малгайгаа толгойдоо өмдөө хөлдөө, бээлийгээ гартаа углах гэх мэтийг мэдэж байвал ТИЙМ гэнэ.	

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p style="text-align: center;">19-24 сар</p> 	<i>Хэл яриа-Харилцаа</i>		<ul style="list-style-type: none"> • Хүүхдэд таалагдсан хөгжмийн ая тавьж сонгох, аяны дагуу бүжиглэх хөдөлгөөн, бүжиглэж байгаа хүүхэдтэй номны зураг үзүүлэх, зурагтаар бүжиглэж байгаа хүүхдүүдийг зааж дагаж бүжиглэх хөдөлгөөн хийхийг дэмжих • Хурдан удаан хөдлөхөд тохирсон аяуудыг ээлжлэн тавьж сонгох • Янз бүрийн хөдөлгөөнийг дуурайлгаж хийлгэж байх, заасан хөдөлгөөнөө байнга шалгаж асууж хийлгэж байх. Хүүхдэдээ тоглох болон хөдөлгөөнт дасгал хийхийг зөвшөөрөх. Энд эцэг эх өөрсдөө даган дуурайх сайн үлгэр жишээ болж байх.
	<p>9. Хүүхэд ойр дотны хүмүүсээ баяртай гэж гараараа дохих хөдөлгөөнийг чөлөөтэй хийх</p>	<p>Гарын хөдөлгөөнөөр баяртай, надад өгөөч, авахгүй гэх мэтээ үйлдлүүдээрээ ойлгуулж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.</p>	
	<p>10. Бусдыг дуурайн эргэлдэж гар хөлөө хөгжмийн аяар хөдөлгөж бүжиглэхийг оролдох</p>	<p>Бусдын хийсэн хөдөлгөөнийг дуурайж хийж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.</p>	
	<i>Хөдөлгөөн</i>		
<p>11. Гараа өргөх, даллах, хөлөө өргөж нэг хөл дээрээ зогсох, гарынхаа тохойны үеэр нугалж хөдөлгөх</p>	<p>Гараа өргөх, нэг хөл дээрээ зогсох, тохойгоороо нугалах зэргийг зааж өгөхөд дуурайж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.</p>		


Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p style="text-align: center;">25-30 сар</p> 	<i>Хэл яриа-Харилцаа, Танин мэдэхүй</i>		<ul style="list-style-type: none"> • Хүүхдийнхээ үргэлж тоглодог тоглоомыг үе үе далд хийж нэг хэсэг тоглуулахгүй байж байгаад дараагийнхаа тоглоомыг гаргаж өгөх • Хүүхдийн хийх гэсэн үйлдлийг дэмжиж нөхцлөөр хангах • Хагарч гар хөлийг нь гэмтээхээс болгоомжилж хуванцар аяга таваг зөөлгөх, угаах үйлдлийг дэмжиж урамшуулах
	<p>1. Насандаа тохирсон зурагтай номыг тайлбарлаж амьтны дүрсийг нэрлэнэ.</p>	<p>Амьтны дүрсийг харуулж нэрийг хэлээд гараараа заахыг хүсэхэд зааж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.</p>	
	<p>2. Зураг дээрх дүрсийг нэрлэж заахад нухацтай ажиглах</p>	<p>Зураг дээрх дүрсийг энэ юу вэ гэж асуухад нэрлэж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.</p>	
	<i>Хэл яриа-Харилцаа</i>		
	<p>3. Тоглоомон дүрсүүдийг нэрлэж тоглуулан эргүүлэн асуухад өөрийн ойлгосноо бусдад ойлгуулахыг оролдоно.</p>	<p>Тоглоомыг нь нэрлээд дараа нь асуухад давтан хэлж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.</p>	
	<i>Танин мэдэхүй-Үйлдэх, Хөдөлгөөн</i>		
<p>4. Зураг харж дуурайлган зурах гэж оролдоно.</p>	<p>Харандаагаар дүрс зурах гэж сараачиж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.</p>		

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө	
<p style="text-align: center;">25-30 сар</p> 	<i>Бие дааж хийх үйлдэл-Эрүүл мэнд</i>		<ul style="list-style-type: none"> • Хүүхдийг ойр зуурын ахуйн үйлдэл хийхийг нь дэмжиж тоос арчих алчуур өгөх, дууриаж хийх алх хэлбэрийн тоглоом өгч юм хадаж байгаа хөдөлгөөн зааж сургаж зөв хийсэн үед нь урамшуулж магтаж ахин дахин хийлгэх • Тахиа том эсвэл дэгдээхэй жижигхэн гэх мэтчилэн хүрээлэн байгаа орчноо харьцуулан тайлбарлаж хүүхэдтэйгээ ярилцах 	
	5. Тоос шороо арчих, шүүрээр хог шүүрдэх хөдөлгөөн хийнэ.	Ээжийгээ дуурайж юм угаах сонирхолтой болох, саван ус, шүүр, алчууртай харьцаж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	<i>Хэл яриа-Харилцаа, Танин мэдэхүй</i>			
	6. Хүүхэд тоглоомоо үргэлж сольж, өөр шинэ тоглоомоор тоглохыг хүсч уйдсан тоглоомоо голж тоглохгүй гэдгээ хөдөлгөөнөөрөө харуулах	Өөрөө хүссэн тоглоомоор тоглохыг хүсч бусад тоглоомоо тоохгүй байгаагаа хөдөлгөөн хариу урвалаар үзүүлж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	7. Аливаа юмны том жижиг хэмжээг ялгаж чадах	Амьтан болон янз бүрийн дүрсний том жижиг болох, малын төл, амьтны зулзагыг ялгаж хэлж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	8. Харандаа үзэг зөв барьж юмыг дуурайлган зурах	Өөрөө зурах гэж оролдож ямар нэгэн дүрсийг заах,		
	<i>Хэл яриа-Харилцаа</i>			
	9. Өөрийнхөө хэмжээнд дагаж дуулахыг оролдох, өөрийн гэсэн аялгаар дуурайн дуулах	Дуулаарай гэхэд дуу аялах маягийн авиа гаргаж найгаж хөдөлж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	<i>Бие дааж хийх үйлдэл-Эрүүл мэнд</i>			
	10. Ширээн дээрээс аяга таваг хураах зэрэг үйлдлийг өөрийн хүсэлтээр хийхийг оролдох	Аяга тавагтай харьцах хөдөлгөөнийг эвсэг хийж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p>31-36 сар</p> 	<i>Танин мэдэхүй-Үйлдэх</i>		<ul style="list-style-type: none"> • Чөлөөтэйгээр зурж, бичихийг хүүхдэдээ зөвшөөрөх. • Хүүхдийнхээ зурж, бичсэн зүйлийн талаар түүнтэй ярилцах. • Хайрцаг бол дөрвөлжин, бөмбөг бол бөөрөнхий гэх мэтчилэн юм зүйлийн хэлбэр дүрсний талаар түүнтэй ярилцах • Хүүхдэдээ үлгэр өгүүлэг ярьж, дуу дуулж өгөх • Хүүхдээ шатаар өгсөх уруудахад байнга дэмжлэг үзүүлж явах чадварыг дэмжих • Хоол идэх үед нь тохирсон халбага сэрээ зөв бариулж асгахгүй ам руугаа хоолоо хийж сурах дадлагыг уйгагүй олон удаа зааж дэмжиж өгөх
	1. Гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг ялгах	Ижил дүрсийг ялгаж, эвлүүлэх тоглоомын ижил дүрсийг нийлүүлж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	2. Бороо, цас, шөнө, өглөө, нар, сар гэх мэт үзэгдлийг хэлэхэд ойлгох	Шөнө болж байна яах билээ гэхэд унтана гэж нүдээ аних, бороо орж байна яах билээ гэхэд шүхэр заах, нар хаана байна гэхэд заах гэх мэт үйлдлүүдийг хийж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	3. Юмны учир олох гэж тоглоомоо эргүүлэн тойруулж харах, юмаар цохих, шидэх гэх мэт үйлдэл хийх.	Тоглоомыг хэрхэн хөдөлж, дуу чимээ хаанаас хэрхэн гарч байгаа учрыг олох гэж ахин дахин хөдөлгөж, дуугаргаж үзэх, Жишээ нь машиныхаа дугуйг авч буцааж эвлүүлэх гэх мэт хийж чадаж байвал ТИЙМ гэж үзнэ.	
	<i>Хөдөлгөөн</i>		
4. Хүний хараа хяналтын дор шатны бариулаас барин өөрөө өгсөж буух	Шатаар өгсөж буухдаа хүний дэмжлэггүй байсан ч өөрөө хөлөө өргөж буулгаж, зөөж явж чадаж байвал ТИЙМ гэсэн үнэлгээ өгнө.		

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө	
<p style="text-align: center;">31-36 сар</p> 	<i>Бие дааж хийх үйлдэл-Эрүүл мэнд</i>		<ul style="list-style-type: none"> • Зарим хувцсаа өмсөхөд цаг гаргаж өөрөөр нь өмсүүлэх. Жиш: малгай, бээлий, оймс гэх мэт • Анхаарлыг нь татсан зүйлийг 10 хороо хэтэй үзүүлэх саад болохгүй ажиглаж нүүр хөдөлгөөний хувирлыг харна • Өөрсдийгөө дууриалган дасгал хийлгэх, бүжиглэх хөдөлгөөн хийлгэх, хөдөлгөөнийг нь зааж өгнө. • Хүүхдэд юмны учрыг тайлбарлан том хүнтэй ярьж байгаа мэт ярилцах түүний үйлдлийг тайлбарлаж өгөх 	
	5. Өөрөө бие даан хооллох, усанд орох, хувцсаа өмсөхөд гэж оролдох	Бие дааж хоолоо идэхээр тэмүүлэх, зарим хувцсаа өмсөх гэж оролдож байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	<i>Нийгэмшихүй</i>			
	6. Томчуудын хийдэг үйлдлийг дуурайна.	Хүүхэлдэй бүүвэйлэх, бусдын хийж буй хөдөлгөөнийг дуурайж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		
	<i>Танин мэдэхүй-Үйлдэх</i>			
	7. Хүүхэд үлгэр ярих, сонирхолтой хүүхдийн киног тогтвортой сууж чагнах	Өөрийн сонирхсон зүйлдээ анхаарлаа төвлөрүүлж хийж чадаж байвал ТИЙМ гэнэ.		
<i>Хэл яриа-Харилцаа</i>				
8. Богино үетэй үг оролцсон шүлгийг зааж өгөхөд цээжилж уншина.	Богино үетэй шүлэг зааж өгөхөд давтаж цээжээр уншиж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.			

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө	
<p>37-48 сартай</p> 	<i>Бие дааж хийх үйлдэл-Эрүүл мэнд</i>		<ul style="list-style-type: none"> Хүүхдэд тохирсон шүдний оо сойз бэлтгэж өгч, шүд угаах аргыг зааж өөрсдөө харуулж дагуулж хийх хөдөлгөөнийг зааж өгнө. Хайчийг зөв барьж дүрс хайчлахыг зааж өгнө. Хүүхдийн сүнирхсон хүүхэлдэйн кино, үлгэрийн баатруудын дүрс бүхий зургийг тайлбарлан өгч хийх үйлдлийг ярьж өгч дэмжинэ. 	
	1. Шүдээ сойздож угааж оо хэрэглэж чадна.	Шүдний сойз оо өгөхөд бусдын оролцоогүй шүдээ оо хэрэглэж угаахыг оролдож байвал ТИЙМ гэж үзнэ.		
	2. Зааж өгөхөд хоолойгоо зайлж чадна.	Бусдыг дууриаж хоолойгоо зайлж чадаж байвал ТИЙМ гэж үзнэ.		
	<i>Танин мэдэхүй-Үйлдэх, Хөдөлгөөн</i>			
	3. Зураг дүрсийг тойруулан хайчилна:	Хайч бариулахад зөв барьж дүрс хайчилж чадаж байвал ТИЙМ гэнэ.		
<i>Нийгэмшихүй</i>				
4. Дуулж бүжиглэж байгаа хүнийг дуурайн хөгжмийн аяар эвсэлтэй хөдлөх	Олны танил дуучин, бүжигчинг дуурайж дуугарах, хөдөлгөөнийг дуурайж бүжиглэх, дуулахыг оролдож байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.			

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
<p>49-60 сартай</p> 	<i>Бие дааж хийх үйлдэл-Эрүүл мэнд</i>		<ul style="list-style-type: none"> • Өмссөн хувцасны өнгийг зааж өгч байх, юмсыг байнга тоолуулж, хэд байгааг асууж байх, эрхтний үйл ажиллагааг тайлбарлан хэлж өг. • Юмны сайн муу, муухай сайхныг харьцуулан ярьж ойлгуулж буцааж асууж ярилцаж байх, Тод өнгийг өөрийн нь хувцас тоглоомон дээр хэлж нэрлэж нүдлүүлэх дасгалыг байнга хийж байх.
	1. Хувцсаа өөрөө сонгон өмсөх, өөрөө товчлох	Цамц өмдөө бусдын дэмжлэггүй өмсөхийг оролдох, өөрийн хувцсаа ялгаж чадах,	
	<i>Танин мэдэхүй-Үйлдэх, Хэл яриа-Харилцаа, Нийгэмшихүй</i>		
	2. Тоо тоолох	8 хүртэл тооны юмсыг (шагай, шувуу гм) зөв тоолох, Тоолж үзүүлэхэд дуурайн тоолж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	3. Биеийн бүх эрхтнээ зөв хэлэх	Өөрийнхөө эрхтнүүдийг зөв нэрлэж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	4. Өнгө ялгах	Өнгийг ялгаж хэлэх, хэлсэн өнгийг зөв зааж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	5. Аливаа зүйлсийн сайн мууг ялгаж чадна.	Хүүхдээс ямар нэг зүйлийн сайн муу, сайхан муухайг асуухад ялгаж хэлж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
6. Өөрсдөө өнгө ялгаж будах, дүрс хэлэхэд харахгүй дүрсэлж зурж чадах	Хэлсэн дүрсийг тохирсон өнгөөр будаж хэлсэн дүрстэй төстэй дүрс зурж чадаж байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.		

Хүүхдийн нас	Хүүхдийн хөгжил	Үнэлэх арга	Эцэг эхэд зориулсан зөвлөгөө
	<i>Хөдөлгөөн</i>		<ul style="list-style-type: none"> • Зарим зүйлд өөрөөр нь сайн муу талаар дүгнэлт гаргуулж яриулж сайн үйлдлийг дуурайх хүсэл төрүүлж байх. • Хүүхэд харайж дэвхцэх, чөлөөтэй хөдөлж байх орчинг бүрдүүлэх, зориулалтын талбайд тоглуулж байх • Үлгэр уншиж ярьж өгөх, номонд сонирхолтой болгоход зурагтай ном уншуулах. Сайн хийдэг үйлдлүүдийг бусдад магтаж байнга урамшуулж байх
	7. Нэг хөл дээрээ дэвхцэн харайх гүйх,	Хүүхэд харайх, догонцох хөдөлгөөнийг бусдын дэмжлэггүй хийж чадаж байвал, ТИЙМ гэж тэмдэглэнэ.	
	<i>Хэл яриа-Харилцаа</i>		
	8. Үлгэр ярих, зохиож ярих, зүйр цэцэн үг хэлэх	Ярьсан үг өгүүлбэр нь ойлгомжтой авцалдаатай байвал ТИЙМ гэж тэмдэглэнэ.	

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ

ЭХЭМД-ийн сүүл хэсэгт хүүхдийг өвчилсөн үед гэрээр үзүүлэх асаргаа, аюултай шинжүүд, хүүхдийг хэрхэн хооллох, нэмэгдэл хоолыг хэрхэн бэлтгэх зааврыг хавсаргасан байгааг эцэг эхэд тайлбарлаж өгөх ба гэр бүлд энэ талаар утсаар зөвлөгөө өгч болох тухай ч зөвлөж болно.

ЭХЭМД-ийн “ӨСӨЛТИЙН ХҮСНЭГТИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ” хэсэгт хүүхдийн өсөлтийн хүснэгтийг хэрхэн тэмдэглэх, өсөлтийн муруйг үнэлгээг хийх заавар байгаа бөгөөд үүнийг өрх, сумын ЭМТ-ийн эмч сувилагчид хүүхдийг жинлэх, урт, өндрийг хэмжих талаар нэгдсэн ойлголттой байх ба хэмжилт хийснээ өсөлтийн муруйд нямбай тэмдэглэнэ.

Хүүхдийн эрүүл мэнд хөгжилтэй холбоотой өвөрмөц асуудлыг тусгайлан тэмдэглэж, хөгжлийн хоцрогдол бэрхшээлийн эрсдэлтэй хүүхдийг холбогдох эмч, мэргэжилтэн, байгууллага руу илгээх, холбон зуучлах нь анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгэн хэсэг үүрэг юм.

Тухайлбал хүүхдийн ээлжит хяналт үзлэг болон урьдчилан сэргийлэх үзлэгээр ямар нэг өөрчлөлт, хоцрогдол (жишээ нь: сонсгол гэх мэт) илэрч байвал хүүхдийн болон төрөлжсөн мэргэжлийн (чих хамар хоолой, сонсголын г.м) эмч мэргэжилтэнд илгээж ямар дүгнэлт гарч байгааг шалгана.